



СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ

МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

ДУГААР: 2022/01

МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН
ЕРӨНХИЙ ХОРОО



gec.gov.mn



GEC Mongolia



Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо



РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ЭРХЛЭГЧ

Б.Оюумаа

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн дарга

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

П.Алтанчимэг

Мэдээллийн технологийн төвийн ахлах референт

ЗӨВЛӨХ

Ж.Амарсанаа

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор

ГИШҮҮД

Д.Бат-Эрдэнэ

Хуулийн хэлтсийн дарга

З.Бадмаараг

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн референт

Т.Наранбат

Хуулийн хэлтсийн ахлах шинжээч

Г.Ариунболд

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн ажилтан

Ш.Сүхбаатар

Хууль зүйн ухааны доктор, судлаач

С.Оюунтуяа

"Сонгогчдын боловсрол төв" ТББ-ын гүйцэтгэх захирал

Ч.Сайнсанаа

Чимид сангийн гүйцэтгэх захирал

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

Бүтээлийн зохиогчийн болон орчуулгын эрх хуулиар бүрэн хамгаалагдсан болно. Бүтээлийг бүтнээр болон хэсэгчлэн хувилах, нийтлэх, цахим хэлбэрт оруулах, микрофильм хийх бусад ямар нэг хэлбэрээр олшруулахыг хатуу хориглоно.

Мөнхийн үсэг ХХК-д хэвлэв.



Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
30 жилийн ойд зориулав.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГА



01

05

СОНГУУЛИЙН
БОЛОВСРОЛД

02

17

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

03

27

ЯРИЛЦЛАГА,
НИЙТЛЭЛ

04

41

СУДАЛГАА

05

53

СОНГУУЛЬ ДЭЛХИЙН
УЛС ОРНУУДАД

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо нь Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиар ард нийтийн санал асуулгын болон сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, энэ талаар сургалт, судалгаа явуулах болон сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах үүрэг хүлээдэг билээ. Энэ ч утгаараа сонгогчийн боловсролд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээг идэвхжүүлэх, сонгогчдод чиглэхээс гадна сонгуульд оролцогч бүх талд хүргэх мэдээ, мэдээллийг идэвхжүүлэх, сонгуулийн боловсролыг бүх нийтэд тэгш, хүртээмжтэй хүргэхэд анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн сонгох, сонгогдох эрхийг бүрнээ эдлүүлэхийн тулд сонгуулийн төв байгууллагаас онцгойлон анхаарч, сонгуулийн бүх нийтийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор өөрийн болон гадаад орнуудын сонгуулийн эрх зүй, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл, эрдэмтэн, судлаачдын онол практикт суурилсан судалгааны материал, нийтлэл зэрэг олон талын мэдээллийг багтаасан, танин мэдэхүй, судалгааны баримтуудыг эмхэтгэн нийтэд хүргэхээр “Сонгуулийн боловсрол” товхимолын эхний дугаарыг Та бүхэнд толилуулж байгааг хүлээн авна уу.

Сонгуулийн эрх зүйн орчин, тогтолцоо, үйл явц, сонгогчдын оролцооны талаар дотоодын төдийгүй гадаадын болон олон улсын байгууллага, судлаачдын хийсэн судалгаа шинжилгээний үр дүнг энэхүү товхимолоор дамжуулан хүргэснээр цаашдын үйл ажиллагааг судалгаанд суурилан төлөвлөхөд дэм болох учиртай.

Сонгуулийн ерөнхий хорооны албан хаагчид, сонгуулийн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл болон эрдэмтэн судлаачдын хамтын ажиллагааны үр дүнд бүтээгдэж буй энэхүү товхимол нь сонгуулийн талаар сонирхон судалдаг хэн бүхний шинжлэн судлах, сурч мэдэх ажилд бодитой хувь нэмэр оруулах эх сурвалжуудын нэг болно хэмээн найдаж байна.

БЯМБААГИЙН ОЮУМАА



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛД

- Сонгууль гэж юу вэ? Яагаад сонгуульд оролцох ёстой вэ?
- Ардчилсан сонгууль, түүний зарчмууд
- Сонголт-сонгогчийн боловсрол
- Сонгуулийн товчоон
- Монгол Улсын тусгаар тогтнолын төлөө 1945 оны бүх ард түмний санал хураалт

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

05

СОНГУУЛЬ ГЭЖ ЮУ ВЭ?

ЯАГААД СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ЁСТОЙ ВЭ?

“Сонгуулийн эрх бүхий иргэдийг оролцуулан санал хураалт явуулах замаар улс төрийн шийдвэр гаргах үйл явц”-ыг сонгууль гэдэг. Улс төрийн шинжлэх ухаанд сонгуулийг “ард түмний бүрэн эрхт байдал, олонхын удирдлагын үзэл санааг хэрэгжүүлэгч” гэж үздэг бол эрх зүйн шинжлэх ухаанд “Үндсэн хуулиар иргэдэд олгосон сонгох болон сонгогдох эрхийн баталгаа” гэж үздэг. Аль ч тохиолдолд сонгууль нь ардчиллын гол үнэт зүйл бөгөөд тогтмол, чөлөөтэй, шударга явагддаг байх нь ардчиллын хамгийн чухал хэмжүүрийн нэг болдог билээ.

Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, Улсын Их Хурлын гишүүдийг ДӨРВӨН жил тутам, Монгол Улсын Ерөнхийлөгчийг ЗУРГААН жил тутам тогтмол явагддаг сонгуулиар сонгодог.

Бидний өдөр тутмын амьдрал “сонгууль”-иар байгуулагддаг төр засгийн байгууллагуудын гаргаж буй бодлого, шийдвэрээс ямагт хамааралтай байдаг гэдгийг бид мэднэ. Сонгуульд оролцож, саналаа өгөхгүй бол таны хүсэл зориг төрийн бодлого шийдвэрт тусгалаа олж чадахгүй. Сонгууль гэдэг нь иргэд сонгогчдын санаа бодол, хүсэл зоригийг төрийн бодлого, шийдвэрт тусгуулах гол арга хэрэгсэл болох бөгөөд бид өөрсдөдөө ээлтэй ирээдүйг бий болгох, хүсч буй сайхан амьдралаа бүтээхийн эхлэл гэж үзэж сонгуулийн үйл явцын талаар тодорхой ойлголттой байх учиртай.

Ийм ч учраас сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн дэвшүүлж буй бодлого, мөрийн хөтөлбөрийг судалж, үнэлж дүгнэн харьцуулж, сонгуулийн үйл явцад идэвхтэй, хариуцлагатайгаар оролцож, саналаа өгөх нь бидний өөрсдийнхөө төлөө хийж буй хамгийн том алхам болох юм.



Ардчилсан улс орнуудад сонгууль дараах үндсэн шалгуурыг хангасан байх ёстой гэж үздэг:

Сонгууль нь тодорхой хугацаанд тогтмол явагддаг байх;

Сонгуулийн бэлтгэл ажил, санал хураалт, сонгуулийн үр дүн, сонгуулийн дараах бүхий л үйл явц улс төрийн эрх чөлөөт нөхцөлөөр хангагдсан байх;

Сонгуульд өрсөлдөж буй нам, эвсэл, нэр дэвшигчид засгийн эрхийн төлөө шударгаар, чөлөөтэй, адил тэгш өрсөлдөх боломжоор хангагдсан байх;

Сонгуулийн үйл явцад жендерийн тэгш байдлыг хангах;

Сонгуульд оролцож саналаа өгч буй сонгогч сонголтоо чөлөөтэй хийх боломжоор бүрэн хангагдсан байх.

Эдгээр шалгуур нь сонгуульд өрсөлдөж буй оролцогчдын хувьд гарааны тэгш байдал, сонгуулийн кампанит ажил, үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө санхүү, хандивын хэмжээ, мэдээллийн хүртээмж, ухуулга сурталчилгаа хийх, мэдээллийн хэрэгсэл ашиглах боломж зэрэг сонгуулийн бүхий л үйл явцад адил тэнцүү эрх эдэлж, үүрэг хүлээх ёстой гэсэн агуулгыг илэрхийлдэг.

Дээр дурдсанчлан сонгуульд оролцож, саналаа өгөх эсэх нь тухайн сонгогчийн эрх боловч сонгуулийн ирц, сонгогчдын оролцоо нь төрийн болон орон нутгийн эрх барих байгууллагын иргэд-сонгогчдыг төлөөлөх байдал, сонгууль зохион байгуулахад зарцуулах төсөв, хөрөнгөтэй холбоотой болохоос гадна цаашилбал, сонгуульд саналаа өгөөгүй бүлгийн эрх ашигтай ч холбогддог.

“ИРЦ ӨНДӨР” СОНГУУЛЬ

Иргэдийн итгэл хүлээсэн, олонхын санал авсан төлөөлөгч сонгогдоно.

Бидний татварын мөнгөөр зохион байгуулж буй сонгууль ирцээс шалтгаалан дахин явагдахгүй.

Иргэдийн олонхын саналаар сонгогдсон нам, эвсэл Засгийн газраа байгуулан мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж эхэлнэ.

Олонхын саналаар сонгогдсон төлөөлөгчөөр дамжуулан нийт иргэдийн эрх ашигт нийцсэн төрийн бодлого хэрэгжинэ.

“ИРЦ БАГА” СОНГУУЛЬ

Цөөн сонгогчийн саналын үр дүнгээр сонгогдсон төлөөлөгч нийт иргэд, олонхын эрх ашгийг бүрэн илэрхийлж чадахгүй.

Ирц хүрэхгүй бол сонгуулийг дахин зохион байгуулж, төсвийн үргүй зарлага нэмэгдэнэ.

Цөөнхийн саналаар гарсан нам, эвслийн бодлого, үйл ажиллагаа нийт иргэдийн эрх ашигт нийцэхгүй байх магадлалтай.

Цөөнхийн саналыг дагаж мөрдөхөөс өөр аргагүйд хүрнэ.



Бүгд Найрамдах Солонгос Улсын КОЙКА байгууллагын санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй төслийн “Хариуцлагатай сонгогч” сургалтын хөтөлбөрөөс

СОНГУУЛИЙН ҮНДСЭН ЗАРЧМУУД

Докторант П.Алтанчимэг,
Мэдээллийн технологийн төвийн ахлах референт



Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж Улсын Их Хурлын гишүүдийг дөрвөн жил, Монгол Улсын Ерөнхийлөгчийг 6 жилийн хугацаатай тогтмол явагдах сонгуулиар¹ сонгодог.

Манай улсын нэгдэн орсон “Иргэний болон улс төрийн эрхийн тухай пакт”-ад “...Иргэн бүр аливаа алагчлалгүйгээр болон үндэслэлгүй хязгаарлалтгүйгээр дараах эрх, боломжийг эдэлнэ”² хэмээн заасанчлан ардчилсан сонгуулийн үндсэн зарчмын дагуу жинхэнэ ёсоор, тогтмол явагддаг сонгуульд сонгогдох буюу сонгох эрх, сонгуулийн бүх нийтийн, тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжийг Монгол Улсын Үндсэн хууль болон сонгуулийн тухай хууль тогтоомжоор хуульчлан баталгаажуулсан.

1. Сонгууль бүх нийтийн байх зарчим



Сонгууль нь бүх нийтийн байх бөгөөд түүнд сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр оролцох эрхтэй.³

2. Тэгш эрхийн зарчим



Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй, санал бүр ижил жинтэй байх тухай ойлголт юм. Сонгогчийн гарал үүсэл, шашин шүтлэг бусад хүчин зүйлсээс үл хамааран сонгогчдын санал адилхан тоологдох ёстой.

3. Шууд оролцох эрхийн зарчим



Та саналаа ямар нэгэн төлөөлөлгүйгээр зөвхөн өөрөө биечлэн өгнө. Харин хvндэтгэн vзэх шалтгааны улмаас өөрийн биеэр саналын хуудсыг бөглөж чадахгvй бол сонгуулийн хуульд заасны дагуу өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар саналаа өгч болно.

4. Саналаа нууцаар гаргах зарчим.



Сонгогч хэнд саналаа өгөхийг өөрөөс нь өөр хэн ч мэдэх ёсгүй. Саналын нууцлалыг сонгууль зохион байгуулж буй сонгуулийн байгууллага хариуцаж, нууцлалыг хангадаг.

5. Чөлөөтэй сонгох зарчим.



Сонгогч сонгуульд оролцож саналаа өгөх эсэхээ, сонгох, сонгогдох эсэхээ өөрөө шийдвэрлэнэ. Сонгуульд нэр дэвших, сонгох эрхийг албадан эдлүүлэх ёсгүй. Сонгогчийн сонголтод хөндлөнгөөс нөлөөлөх, дарамт шахалт учруулахыг хуулиар хориглодог учраас сонгогч сонгуульд оролцож байгаа нам, эвслийн болон нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөртэй танилцаж, өөрт болон нийгэмд тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдэх тухай ямар бодлого баримтлан ажиллахыг нь шинжлэн дүгнэлт хийж, өөрийн итгэл үнэмшлээр сонголтдоо хийх нь таны гаргаж буй том шийдвэр, ирээдүйдээ оруулж буй том хөрөнгө оруулалт гэдгийг сайтар ойлгох хэрэгтэй юм.

¹ Монгол Улсын Үндсэн хууль -21.2, 31.3

² “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 25 дугаар зүйл

³ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль



Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал 21. 3.



Сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох;

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 25(b)

СОНГОЛТ – СОНГОГЧИЙН БОЛОВСРОЛ

Хуульч, магистрант Д.Бат-Эрдэнэ,
Хуулийн хэлтсийн дарга



Бид насан туршдаа, өдөр болгон, цаг минут бүр сонголт хийх шаардлагатай болдог. Таны хийсэн сонголт бүр та болон таны гэр бүлийн, цаашлаад бусдад ээлтэй байж чаддаг болов уу?

Сонголт бол тухайн хүний хүсэл зоригийн илрэл бөгөөд сонголтоо өөрөө, чөлөөтэй хийх эрх нь ардчилсан нийгмийн үнэт зүйлийн нэг. Энэ ч утгаараа ардчилсан улс орнууд төрийг хэргийг удирдах төлөөлөгчийг сонгох, мөн түүнд сонгогдох эрхийг Үндсэн хуулиараа хуульчлан баталгаажуулсан байдаг. Харин энэхүү эрхээ хэрхэн хэрэгжүүлэх, мөн хэрэгжүүлэхийн үнэ цэнийг ухамсарлан ойлгох нь сонгогчийн боловсролтой шууд холбоотой юм.

Сонгогчийн боловсролын агуулга нь сонгогчдод сонгуульд оролцохын ач холбогдлыг тайлбарлан таниулж, тэднийг сонгуульд мэдлэг мэдээлэлтэй оролцуулахад чиглэгдэх бөгөөд ардчилсан сонгуульд хандах иргэдийн хандлага, зан байдлыг илтгэх учиртай. Сонгогчийн боловсрол нь хэний төлөө санал өгөх вэ гэхээс илүүтэй, саналаа хэрхэн өгөх вэ гэдэгт төвлөрдөг.

Сонгогчийн боловсрол юунд хэрэгтэй вэ?

Сонгогч саналаа өгөхийн тулд зайлшгүй мэдэж байх шаардлагатай зүйлс гэж бий. Сонгогчийн боловсролын өргөн хүрээтэй мэдлэгийг олгох нь сонгогчийн боловсролын үйл ажиллагааны үндсэн зарчим мөн бөгөөд эцсийн дүндээ сонгуулийг шударга, чөлөөтэй явуулах иргэдийн хүсэл зоригийг баталгаажуулах зорилготой.

Боловсролтой сонгогчдыг бэлтгэсэний ачаар сонгогчид сонгуулийн үеэр аливаа амлалт, ухуулгад амархан автахгүй, асуудлыг олон талаас нь эргэцүүлэн дүгнэж, шинжих чадвартай болж “хэрсүүжих”-ээс гадна зар сурталчилгаа, суртал ухуулгыг, ялангуяа худал болон хуурамч мэдээ мэдээллийг ялгаж, бусдын нөлөөнд авталгүйгээр зөвхөн өөрийн үзэл бодлоороо сонголтдоо хийж Үндсэн хуулиар олгогдсон суурь эрхээ хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

Зөвхөн сонгогчийн боловсролоор ардчиллыг бий болгож чадахгүй ч түүнийг хамгаалж чадна хэмээн судлаачид дүгнэдэг⁴.

Сонгогчийн боловсролоор үндсэн гурван мэдлэгийг иргэдэд олгох боломжтой.

⁴ А.Эрхэмбаяр сэтгүүлч “Сонгогчийн боловсрол” нийтлэл

Нэгдүгээрт, саналаа өгөхийн тулд ямар мэдээллийг, хаанаас, хэрхэн олж авах тухай болон мэдээлэлд дүн шинжилгээ хийх арга зүй, хоёрдугаарт, санал авах байранд саналаа хэрхэн өгөх зааварчилгаа, гуравдугаарт, саналаа өгөх нь сонгуулийн эцсийн үр дүнд хэрхэн нөлөөлөх, түүний ач холбогдол зэргийг хамааруулан ойлгож болно.

Сонгогчийн боловсролын суурь мэдээлэл, түүнийг олгох байгууллага

Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны гол онцлог нь хэн, хэзээ, ямар үйл ажиллагааг, хэрхэн хийх ёстойг нарийвчлан зохицуулсан хуулийн хүрээнд явагддаг бөгөөд нэг нь нөгөөгөөсөө шууд хамааралтай процессын үйл ажиллагаа юм. Иймд сонгогч болон сонгуульд оролцогч талуудад, нэр дэвшигчдэд сонгуулийн үйл явцын талаарх мэдээ, мэдээллийг тогтмол өгч байх шаардлагатай байдаг. Сонгуулийн бүхий л үйл явц нээлттэй, ил тод байдлыг хангах зарчимд суурилсан байх бөгөөд түүнийг хангах эрх зүйн орчин хэрхэн бүрдсэн нь түүнд үнэлэлт өгөх нэг шалгуур болдог.

Сонгогчдод сонгуулийн талаарх суурь мэдлэг олгох, ач холбогдлыг тайлбарлан таниулах үйл явц нь тасралтгүй, өргөн хүрээнд хийгдэх ажил тул Сонгогчийн боловсрол олгох үйлыг дан ганц сонгуулийн байгууллага бус бүх шатны боловсролын байгууллага, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагаа чухал. Ихэвчлэн сонгуулийн байгууллагууд, төрийн зарим байгууллага, хүний эрхийн байгууллагууд, сонгуулийн боловсролд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг, улс төрөөс хараат бус олон улсын болоод дотоодын иргэний нийгмийн байгууллагууд сонгогчийн боловсролын тухай сургалт, сурталчилгаа, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зэргийг зохион байгуулдаг. Энэ нь тэдний сонгуулийн үеэрх нийгмийн өмнө хүлээсэн чухал үүрэг гэж үзэж болох юм. Аль нэг нам, улс төрөөс шууд хамааралтай, хараат буюу харьяаны байгууллага сонгогчдод боловсрол олгохоос илүүтэй суртал ухуулга хийх нь элбэг тул үүнээс зайлсхийх хэрэгтэй болдог. Сонгогчийн боловсрол олгох үйл явц нь аливаа улс төрийн нам, эвсэл, улс төрчөөс хараат бусаар явагдах зарчмыг баримтлах нь нэн чухал.

Мөн сонгогчид хаана, хэзээ, хэрхэн саналаа өгөхийг сонгуулийн хороодоос гадна хэвлэл мэдээллийн байгууллагууд өргөнөөр мэдээлэн сайтар танин мэдүүлэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, сонгогчийн боловсрол олгох үйл явц нь тасралтгүй, тогтмол, өргөн цар хүрээтэйгээр олон талын оролцоотойгоор явуулах цогц үйл ажиллагаа юм. Жишээ нь, Канад, Австрали, Финлянд, Аргентин, Мексик, Энэтхэг, Их Британи, Франц, Герман, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс тэргүүтэй улс орнуудад сонгогчийн боловсролын хөтөлбөр сонгуулиас сонгуулийн хооронд тогтмол үргэлжилсээр байдаг аж. Энэ нь сонгогчдыг хэзээд саналаа өгөхөд бэлэн, сонгуульд идэвхтэй оролцоход ихээхэн ач холбогдлоо өгдөг байна.

Харин Хятад, Алжир, Саудын Араб, Чад, Мьянмар, Умард Солонгос, Камерун зэрэг оронд сонгогчийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлдэггүй. Харин Ливи, Казахстан, Польш, Нидерланд, Индонез гэх мэт Бүгд Найрамдах засаглалтай орнуудад сонгогчийн боловсролын талаарх ойлголт маш дутмаг байдаг бол бусад орнуудад зөвхөн сонгуулийн үеэр сонгогчийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлдэг гэсэн олон улсын байгууллагын судалгаа байдаг.



Өмнөх үеийн нэг намт сонгуульд хэнийг нэр дэвшүүлнэ, түүний төлөө саналаа өгч дадсан өвөг дээдсийн удамшилтай шинэ Монголчууд өдгөө цагийн өрсөлдөөнт сонгуульд өөрийн бодолтой оролцож, бие даан шийддэг чадавхыг эзэмших нь төрийн хэрэгт нийтээр суралцахуйн гайхамшигт сургууль мөн болой.


Б.ЧИМИД

Олон улсын хэмжээнд хэрэгжүүлж буй сайн туршлага

Сонгогчийн боловсролын чиглэлээр хэрэгжүүлсэн “VEP -Voter Education Project” төслийг шилдэг хөтөлбөрүүдийн нэгээр судлаачид нэрлэж, дээгүүр үнэлдэг. Энэ нь 1962-1992 оны хооронд АНУ-ын өмнөд хэсэгт авч хэрэгжүүлсэн төсөл бөгөөд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг тэмцэж байсан “Civil Rights Movement” хөдөлгөөний зорилгыг өнгөт арьстнуудын сонгох эрх рүү чиглүүлэх давхар зорилготой байв. CRM хөдөлгөөний ачаар уг төсөл АНУ дахь өнгөт арьстнуудын санал өгөх эрхийг нэмэгдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулжээ.

Тэгвэл одоо идэвхтэй хэрэгжиж буй сонгогчийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрүүдийн нэг нь “ACE Electoral Knowledge Network” цахим хөтөлбөр юм. Сонгогчийн боловсролд зориулсан дэлхийн хамгийн том, сонгуулийн чиглэлээр судалгаа шинжилгээ явуулдаг нэр хүндтэй байгууллагуудыг эгнээндээ нэгтгэсэн цахим сүлжээний цахим хуудсанд сонгуулийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл явцын талаар дэлгэрэнгүй мэдээлэл байдгаас гадна, хэрэглэгчдэд зөвлөгөө өгдөг юм.

Дээр дурдсан сүлжээний цахим хуудас нь сонгуультай холбоотой мэдээллийн томоохон эх сурвалж болох бөгөөд Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн, Сонгуулийн тогтолцооны олон улсын сан, НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газар хамтран 1998 онд үйл ажиллагаагаа эхлүүлж байжээ.⁵



⁵ <https://aceproject.org>

Сэтгүүл зүйн магистр Г.Ариунболд,
Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн ажилтан

1992 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын Их Хурлын анхны сонгуулийг зохион байгуулж, сонгогчдын 95,6 хувь нь саналаа өгөв.

1992

1992 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль батлагдав.

1993 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль батлагдав.

2005 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийг зохион байгуулж, сонгогчдын 74,98 хувь нь саналаа өгөв.

2004 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгууль болж, нийт сонгогчийн 67,22 хувь нь саналаа өгөв.

2006 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Сонгуулийн төв байгууллагын тухай хууль батлагдав.

2008 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хурлын 5 дахь удаагийн сонгуулийг зохион байгуулж, нийт сонгогчдын 76,46 хувь саналаа өгөв.

2013 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг зохион байгуулж, нийт сонгогчийн 66,50 хувь нь саналаа өгөв.

2012 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгууль явагдаж, сонгогчдын 52,90 хувь саналаа өгөв.


2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг шинэчлэн батлав.

2016 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгууль болж, сонгогчдын 60,44 хувь нь саналаа өгөв.

2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг шинэчлэн батлав.

2020 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Улсн Их Хурлын ээлжит сонгуулийг зохион байгуулж, сонгогчдын 73.6 хувь нь сонгуульд оролцож, саналаа өглөө.

2021 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг зохион байгуулж, нийт сонгогчийн 59,29 хувь нь сонгуульд оролцож, саналаа өгөв.



2022

МОНГОЛ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛЫН ТӨЛӨӨ 1945 ОНЫ БҮХ АРД ТҮМНИЙ САНАЛ ХУРААЛТ

Сэтгүүл зүйн магистр Г.Ариунболд
Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн ажилтан



1945 оны 8-р сарын 14-нд “ЗХУ болон Хятад улс найрамдалт холбоо тогтоох хэлэлцээр”-т гарын үсэг зурж, энэхүү гэрээгээр БНМАУ-ын тухай хоёр улс тохиролцохдоо “Японыг ялсны дараа, Гадаад Монголд Ард иргэдийн санал хураалт явуулахыг БНХУ-ын Засгийн газар зөвшөөрөв. Түүний ард иргэд тусгаар тогтнолыг сайшаах эсэхээ шийдвэрлэнэ. Хэрэв ард иргэдийн санал хураалтын дүн тусгаар тогтнолыг сайшаавал БНХУ-ын Засгийн газар Гадаад Монголын тусгаар тогтнолыг одоогийн байгаа хилээр нь зөвшөөрч байна” хэмээсэн байна. Энэ хэлэлцээрт БНХУ буюу Гоминданы Хятадын талаас ерөнхий сайд Сүн Зи Вен, Гадаад яамны сайд Ван Си Зи нар оролцсон бөгөөд мөн өдрөө Ван Си Зыгээс “Монгол Улсын тусгаар тогтнолын асуудлыг ард түмнийх нь санал хураалтын үр дүнгээс шалтгаалан авч үзэж болох юм” гэсэн мэдэгдэл нот бичгийг Монгол Улсад илгээсэн байна. Уг нот бичгийг үндэслэн БНМАУ-ын Бага Хурлын тэргүүлэгчдээс 1945 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн 76 дугаар хурлаас тогтоол гаргажээ. Үүнд “Бүх ард түмний саналыг тус улсын бүх дэвсгэр нутаг дээр 10 дугаар сарын 20-ны өдөр нэгэн зэргээр гаргуулахаар тогтоосугай” хэмээн заасан юм.



Харин БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны 10 сарын 5-ны өдрийн 85 дугаар тогтоолд: “Санал гаргах хуудсан дээр тавьсан өөрийн овог, нэрийн доор “зөвшөөрөх” болон “татгалзах” хоёрын аль нэгийг бичиж, гарынхаа үсгийг зур. Хэрвээ бичиг мэдэхгүй бол баруун гарынхаа эрхий хурууг дар” гэж заасны дагуу 1945 оны 10 сарын 20-нд улс орон даяар тусгаар тогтнолын төлөө бүх нийтийн санал хураалтыг 06:00-23:00 цагийн хооронд явуулж байжээ.



Санал асуулгыг нийт 4251 хэсэгт явуулсан бөгөөд нэрсийн жагсаалтад 494,074 хүн бүртгэгдэж, тэдгээрээс 487,285 хүн буюу нийт сонгогчдын 98.6 хувь нь саналаа өгсөн байна. Харин үлдсэн улс нь буюу 6791 хүн замд явж байсан, өвчтэй зэрэг байсны улмаас санал хураалтад оролцож чадаагүй ажээ. Санал хураалтанд оролцсон бүх хүн БНМАУ-ын тусгаар тогтнолын төлөө саналаа өгсөн түүхэн баримт өнөөдөр Монгол улсын Үндэсний төв архивт хадгалагдаж байна.



1940 он гэхэд Монголчуудын тал хувь нь бичиг үсэг тайлагдсан байлаа. Иймээс санал хураалтыг гарын үсэг болон баруун гарын эрхий хурууны хээгээр баталгаажуулсан байдаг юм. Гарын үсэг зурагчдын дийлэнх нь Монгол бичгээр бичсэн бол кирилл үсгээр тун цөөн хүн гарын үсгээ зурсан байна.



UIH.MN
СУДАЛГААНЫСАН

2

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, түүний нэмэлт, өөрчлөлт
- Улсын Их Хурлын сонгуулийн тоо, баримт
- УИХ-ын гишүүн, Монгол Улсын Ерөнхийлөгч, орон нутгийн хурлын Төлөөлөгчийн бүрэн эрх

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Хуульч Т.Наранбат /LL.M./,
Хуулийн хэлтсийн ахлах шинжээч



Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна”⁶ гэж заасны дагуу төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал, түүний нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгож байна.

Нийт үндэстнийг төлөөлөх эрхийг сонгуулиар шилжүүлэн авсны улмаас хууль тогтоох эрхтэй, хамтын зарчмаар ажилладаг бүлэг хүмүүсийн тогтолцоог хууль тогтоох дээд байгууллага гэнэ. Хууль тогтоох дээд байгууллагын нийтлэг нэршил нь парламент⁷. Улсын Их Хурал буюу Парламент⁸ нь ард түмнээс шууд эх сурвалжтай төлөөллийн дээд байгууллага учраас хууль тогтоохоос гадна төрийн бусад байгууллагыг байгуулахад оролцох, төрийн гадаад, дотоод бодлогыг боловсруулах, улсын төсвийг батлах, засгийн газрыг хянах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.⁹

Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах үндсэн зарчим, журмыг тодорхойлж, түүнтэй холбогдсон харилцааг УИХ-ын сонгуулийн тухай хуулиар зохицуулдаг. Энэ хуулийг УИХ-аас 1992, 2005, 2011, 2015, 2019 онуудад буюу нийт таван удаа шинэчлэн баталсан байна. Дээрх хуулиуд шинэчлэгдэх бүрт сонгуулийн харилцааг улам нарийвчлан зохицуулж, үүнтэй уялдан тус хуулийн ерөнхий бүтэц тэлсэн байна. Тухайлбал, 1992 оны хууль 8 бүлэг 44 зүйл, 2005 оны хууль 11 бүлэг 58 зүйлтэй байсан бол 2019 оны хууль 12

бүлэг 83 зүйлтэй болжээ. Үүний зэрэгцээ он оны хуулиуд өөрийн онцлогтой байж, түүхэн үүргээ биелүүлснийг дараах байдлаар нэг бүрчлэн тоймлож байна.

1992 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль анхны ардчилсан сонгуулийн эрх зүйн харилцааны зохицуулалт бүхий эх хууль юм. Энэ хуулиар 1992, 1996, 2000, 2004 оны парламентын сонгуулийг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулжээ.

Нийгмийн харилцааны төлөв байдал өөрчлөгдсөнтэй уялдуулан сонгуулийн зохион байгуулалтын үйл ажиллагааг илүү нарийвчлан зохицуулах шаардлагын үүднээс хууль тогтоогч УИХ-ын сонгуулийн хуулийг 2005 онд шинэчлэн баталжээ. Энэ хуулиар сонгуульд нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх, сонгуулийн сурталчилгаа хийх зэрэг харилцааг илүү нарийвчлан зохицуулсан. Энэ нь уг хуулийн онцлог байв.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны сонгуульд анх удаа гэж тодотгохуйц олон үйл явдал болжээ. Тухайлбал, анх удаа сонгуулийн хосолсон тогтолцоогоор сонгууль зохион байгуулсан. Мөн гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажиллагааг анх удаа зохион байгуулсан. Түүнчлэн сонгуулийн дүнг гаргах ажиллагаанд автомат тоолох хэрэгслийг анх удаа практикт нэвтрүүлсэн байна. 2011 онд батлагдсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар дээрх харилцааны эрх зүйн үндсийг тавьжээ.

⁶ Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.

⁷ Н.Лүндэндорж. Төрийн онол. 2020 он. 168 дахь тал.

⁸ Улс үндэстний түүхэн уламжлал, хэл соёлоос хамаарч янз бүрээр нэрлэдэг. Тухайлбал, АНУ-д Конгресс, Польшид Сейм, ОХУ-д Дум, Германд Бундестаг гэх мэт.

⁹ Мөн тэнд.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ



Хууль тогтоогч 2015 онд “Сонгуулийн тухай хууль”-ийг баталсан. Энэ хуулиар Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үндсэн зарчим, журмыг тодорхойлж, эдгээр сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан. Өөрөөр хэлбэл, тусдаа хуулиар зохицуулагдаж байсан гурван сонгуулийн харилцааг нэг хуулиар зохицуулах гэж оролдсон. Энэ оролдлого нь хууль хэрэглээний хувьд давхардал, хийдэл, ойлгомжгүй зүйл бий болгож байсан нь 2019 онд УИХ-ын сонгуулийн тухай хуулийг бие даасан хууль болгон батлах үндэслэлүүдийн нэг болсон юм.

Дээр дурдсан үндэслэлийн зэрэгцээ УИХ-ын сонгуулийг зохион байгуулахад тухайн харилцааны зохицуулалтыг улам нарийвчлах нь хангалтгүй байсан учраас хөндлөнгийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, сонгуулийн зардлыг ил тод болгох улмаар сонгогч мэдээлэлтэй болж сонголтоо хийх боломжийг сонгогчид олгох эрх зүйн орчин бүрдүүлэх зорилго тавьж, парламент Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг 2019 онд баталжээ. Энэ нь 5 дахь

удаагийн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль юм.

Эдгээр парламентын сонгуулийн тухай хуулиудад 1992, 1996, 2008, 2012, 2015, 2016, 2019 онуудад өөрчлөлт орж байв. Хууль тогтоогчийн санаачлагаар 1992 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт орж байсан бол үүнээс хойших хуулиудад ихэвчлэн Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн дагуу өөрчлөлт орж байсныг нэмж дурдъя.

СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИУДАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ОН

▼ 1992

▼ 2015

▼ 1996

▼ 2016

▼ 2008

▼ 2019

▼ 2012

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

1992

НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ



1 зүйл, 7 хэсгийг 1996
оны хуулиар өөрчлөн
найруулсан.

2005

НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ



7 зүйл, хэсгийг хүчингүй
болсонд тооцсон, 21
зүйл, хэсэгт өөрчлөлт
оруулж, 9 зүйл хэсгийг
өөрчлөн найруулсан, 6
зүйл хэсгийг нэмсэн.

2011

НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ



2 зүйл, хэсгийг хүчингүй
болсонд тооцсон.
3 хэсэгт өөрчлөлт
оруулж,
1 хэсгийг өөрчлөн
найруулсан, 1 заалт
нэмсэн.

2019

НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ



3 хэсэгт өөрчлөлт
оруулж,
2 хэсгийг хүчингүй
болгосон.



УИХ-ЫН ГИШҮҮН, МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ, ОРОН НУТГИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХ /ИНФОГРАФИК/

Докторант П.Алтанчимэг,
Мэдээллийн технологийн төвийн ахлах референт



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХЭЭС

1



Хуулийн төсөл санаачлах, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл санаачлах

2



Улсын Их Хурлаас сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтны илтгэл, сонгол хэлэлцүүлэх саналыг Байнгын хороонд оруулах

3



Ерөнхий сайдыг огцруулах саналыг Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын бусад гишүүнтэй хамтарч гаргах

4



Нийтийн сонсгол зохион байгуулах санал гаргах

5



Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад асуулга, асуулт тавьж хариуг хуульд заасан хугацаанд авах эрхтэй



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХЭЭС

6



Иргэн, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан хариу өгөх, эсхүл харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжилж энэ тухай хариу мэдэгдэх

7



Хөрөнгө, орлогын мэдүүлгийг тогтоосон хугацаанд зохих журмын дагуу үнэн зөв гаргах

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХЭЭС

1



УИХ-ын анхдугаар чуулганыг товлон зарлах, улс орны чанартай хойшлуулшгүй чухал асуудлыг хэлэлцүүлэхээр УИХ-ын ээлжит бус чуулган чуулахыг санаачилна

2



Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай Ерөнхий сайдаас тавьсан саналын талаар түүнтэй зөвшилцөнө

3



Хууль санаачлах, хуулийн төслийг УИХ-ын даргад өргөн мэдүүлнэ

4



УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавина

5



Өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх. Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно

6



Гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах

7



Улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХЭЭС

8



Үучлал үзүүлэх

9



Монгол Улсын харьяат болох,
харьяатаас гарах, тус улсад
орогнох эрх олгох асуудлыг
шийдвэрлэх

10



Монгол Улсын үндэсний аюулгүй
байдлын зөвлөлийг тэргүүлэх

ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХЭЭС

1



Хурлын даргыг сонгох, чөлөөлөх,
огцруулах

2



тухайн шатны Засаг даргыг
томилуулахаар нэр дэвшүүлэх

3



Засаг даргын үйл ажиллагааны
хөтөлбөрийг батлах, тайланг
хэлэлцэж, үйл ажиллагаанд нь
үнэлэлт, дүгнэлт өгөх

4



Засаг даргыг огцруулах талаар
дээд шатны Засаг дарга, эсхүл
Ерөнхий сайдад санал тавих

5



нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд
хугацааны бодлого, жилийн
эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх
үндсэн чиглэлийг батлах, түүнд
нэмэлт, өөрчлөлт оруулах

6



Засаг даргын өргөн мэдүүлснээр
тухайн аймаг, сум, нийслэл,
дүүргийн төсвийг хэлэлцэж
батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт
оруулах, гүйцэтгэлийг батлах

7



хуулиар тогтоосон хязгаарын
хүрээнд албан татвар, төлбөр,
хураамжийн хувь хэмжээг
тогтоох

8



орон нутгийн өмчийн зүйлсийн
өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх

9



худалдаа, үйлчилгээний төрөл,
ангилал, худалдаа үйлчилгээ
эрхлэхэд тавих шаардлага,
бүрдүүлэх баримт бичиг,
худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн
эрх, үүргийг тодорхойлсон
нийтлэг журам батлах

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ

СОНГУУЛИЙН
огноо

Сонгуульд нэр
дэвшигчийн
тоо

МАНДАТЫН
тоо

1990 07/29
ОНЫ СОНГУУЛЬ

2413

430

1992 06/28
ОНЫ СОНГУУЛЬ

293

76

1996 06/30
ОНЫ СОНГУУЛЬ

302

76

2000 07/02
ОНЫ СОНГУУЛЬ

602

76

2004 06/27
ОНЫ СОНГУУЛЬ

244

76

2008 06/29
ОНЫ СОНГУУЛЬ

356

76

2012 06/28
ОНЫ СОНГУУЛЬ

544

76

2016 06/29
ОНЫ СОНГУУЛЬ

498

76

2020 06/24
ОНЫ СОНГУУЛЬ

606

76

1990-2020

Сонгогдсон
ДЕПУТАТ / ГИШҮҮДИЙН ТОО
намын харьяалаар

САНАЛ ӨГСӨН
сонгогчдын ирц

357 16 6 4 39 9
МАХН МоАН МУДН МСДН БИЕ
ДААГЧ ЭМЭГТЭЙ
ГИШҮҮН

1,027,100
сонгогч

98%

70 4 1 1 3
МАХН МоАН МУДН, НН МСДН БИЕ
ДААГЧ ЭМЭГТЭЙ
ГИШҮҮН

1,085,129
сонгогч

95.6%

25 50 1 7
МАХН АХ ЭВСЭЛ МУНН ЭМЭГТЭЙ
ГИШҮҮН

1,147,260
сонгогч

92.1%

72 1 1 1 1 8
МАХН МУАН МСДН ИЗ ЭХ БИЕ
АХЭВСЭЛ НН ОРОН ДААГЧ ЭМЭГТЭЙ
МАШСН ГИШҮҮН

1,247,033
сонгогч

82.4%

37 35 1 3 5
МАХН ЭХ ОРОН АРДЧИЛАЛ БНН БИЕ
ЭВСЭЛ ДААГЧ ЭМЭГТЭЙ
ГИШҮҮН

1,279,516
сонгогч

82.2%

44 29 1 1 1 3
МАХН АН ИРГЭНИЙ ЭВСЭЛ ИЗН БИЕ
ДААГЧ ЭМЭГТЭЙ
ГИШҮҮН

1,542,617
сонгогч

76.5%

26 34 2 11 3 11
МАН АН ИЗНН МАХН МУАН ШЕЭ БИЕ
ДААГЧ ЭМЭГТЭЙ
ГИШҮҮН

1,836,548
сонгогч

67.3%

65 9 1 1 13
МАН АН МАХН БИЕ
ДААГЧ ЭМЭГТЭЙ
ГИШҮҮН

1,911,047
сонгогч

73.58%

62 11 1 1 1 13
МАН АН ТБ ЗХ БИЕ
ЭВСЭЛ ЭЛЕКТОРАТ ДААГЧ ЭМЭГТЭЙ
ГИШҮҮН

2,132,294
сонгогч

73.6%



Хугацаа	Тайлбар	Хугацаа	Тайлбар
1	Бүтээгдэхүүн	2000	1000
2	Хүний нөөц	2000	1000
3	Хүний нөөц	2000	1000
4	Хүний нөөц	2000	1000

ОНМН
СҮДАЛГААНЫ САН



3

ЯРИЛЦЛАГА, НИЙТЛЭЛ

- Академич Ж.Амарсанаа: Үндсэн хууль болон үндэсний хууль тогтоомжид иргэдийн сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулсан байдал
- Д.Энхцэцэг: “сонгуулийн тогтолцоог илүү хувь тэнцүүлсэн болгож, шинэчлэх шаардлагатай”
- С.Оюунтуяа: Сонгуулийн байгууллагын хараат бус байдал, Олон улсын хөгжлийн чиг хандлага

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

27

АКАДЕМИЧ Ж.АМАРСАНАА:

ТЭНДЭЭС ОЛЖ ИРСЭН НЭГ ОЛЗ НЬ ОДООГИЙН “СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГА” ЮМ



Энэ удаагийн дугаартаа Академич Ж.Амарсанааг зочноор урьж, товч ярилцлага хийлээ. Тэрбээр энэхүү товхимолын редакцын зөвлөлийн зөвлөхөөр ажиллаж байгаа билээ.

-Таныг сонгуулийн эрх зүйг боловсронгуй болгоход оролцож ажилласан гэж сонслоо. Дурсаж ярих зүйл их байгаа даа, танд?

-1990 оны Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль нь шинэ Үндсэн хууль болох суурь болсон юм. Б.Чимид профессор дуудаж, үе үе санал солилцдог байлаа. Гэхдээ энэ төсөл үндсэндээ тэр хүний “гараас гарсан” гэдгийг хэлэх нь үнэнд нийцнэ. Шинэ Үндсэн хууль бэлтгэхтэй холбогдуулан 1991 оны наймдугаар сард Улсын Бага Хурлын томилолтоор Улсын Бага Хурлын Гадаад харилцааны хэлтсийн дарга Б.Алтангэрэл, Тамгын газрын ажилтан Б.Энэбиш, Хууль зүйн сайд Ж.Амарсанаа бид гурав АНУ-ын Калифорни мужийн Сан-Франциско хотноо сонгуулийн асуудлаар болсон олон улсын хуралд оролцож, үг хэлсэн юм. Тэндээс олж ирсэн нэг “олз” бол одоогийн “Сонгуулийн төв байгууллага” юм.

-Ирэнгүүтээ л хууль боловсруулах ажилд оролцов уу? Ямар хуулийн төсөл боловсруулахад нь оролцсон бэ?

-Улсын Их Хурлын гишүүн Лу.Болд, профессор Б.Чимидэд сонгуулийн хуулийн төсөл бэлтгэх санал тавьсан юм билээ. Үүний дагуу бидний долоон хүнийг Ч.Чимид багш Санзайн амралтад дагуулж очиж, долоо хоног ажиллаж, төслийн эх бэлтгэсэн юм. Хүн хүнд ажил хуваарилж өгөөд өдөр, шөнөгүй сууж, төслийн эх гаргасан. Чиглэл нь пропорциональ оролцсон холимог загвар. Энэ нь үндсэндээ Герман бүтэц. Хүнд санал өгнө. Бас намд санал өгнө. Гэхдээ намынх нь ард хүний нэр байх юм. Энэ бол нэлээд илэн далангүй тогтолцоо.

-Сүүлийн үед Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлаасаа сонгодог болж гэж бичих болж. Таны бодол?

-Монгол орон дэндүү донсолгоотой, ороо бусгаа цагт арай эртдэх байх даа.

-Сонгуулийн тогтолцооны асуудлаар Үндсэн хуулийн цэцээс шийдвэр гаргасан. Өөрөөр хэлбэл, “шууд сонгох” гэдэг нь мажоритар тогтолцоонд хамааралтай гэсэн утгаар.

-Анхан шатны сонгууль шууд байдаг. Энэ нь ердөө л сонгогч шууд сонгоно гэсэн үг л дээ. Шууд биш гэдэг нь завсар нь “Сонгогчдын зөвлөл” байгуулахыг хэлж байгаа юм. Дээд шатны байгууллагаараа дамжуулан олон шатаар сонгохыг хэлнэ.

-Б.Чимид доктор сонгуулийн тухай хэд хэдэн бүтээл гаргаж олон нийтэд хүргэж байсан. Одоо ч эрэлт ихтэй гарын авлагууд гэж боддог.

-Түүний “Үндсэн хуулийн мэдлэг” /2 ч удаа хэвлэгдсэн/, “Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний Үндсэн хууль буруутай юу” /2011/, “Сонгуульд суралцахуй: Тогтолцоо, үйл

явц, эрх зүй” /2008/ зэрэг хэд хэдэн бүтээл бий. Ер нь “Сонгуульд суралцахуй” номыг нь танайх цувралаар гаргачихад их зүгээр. Урьд нь ярьж, бичиж байгаагүй юм их бий. Онол, арга зүйн талаас тайлбарласан зүйл ч олон байгаа. Сонгуультай холбоотой хуулиуд дээр ажилласан хуулийн төслийн эхийг дагнан судалбал зүгээр сэн. Одоо ингээд товчлоё. Удахгүй болох эрдмийн хуралд арай дэлгэрэнгүй илтгэнэ. Өөрийнхөө тухай арай их ярьчихав уу даа. Ер нь цаашид танай мэдээ, мэдээллийн товхимолд

өөрөө ч бичиж байя, эрдэмтэн, судлаачдад хэлж, хүсэлт тавьж бичүүлж байя гэж бодож байгаа шүү.

-Цаг зав гаргаж ярилцсанд баярлалаа.

Ярилцсан: З.Бадмаараг

Мэдээлэл, судалгаа,
сургалтын төвийн референт



Монгол Улсад шинжлэх ухааны академич цолтой хоёр хуульч байдаг ба тэдний нэг нь Жүгнээгийн Амарсанаа. Тэрбээр хуулийн мэргэжил эзэмшсэн цагаасаа хойш буюу 1975 оноос МУИС-д багш, тэнхимийн орлогч эрхлэгч, орлогч декан, Хууль зүй, арбитрын яамны газрын дарга, Хууль зүйн сайд, Хууль зүйн үндэсний төвийн захирал, Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, даргаар ажилласан.

- 1975 – 1981 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд Хүний эрхийн олон улсын эрх зүйн багш, тэнхимийн орлогч эрхлэгч
- 1981 – 1990 онд Хууль зүйн яамны хэлтэст газрын дарга
- 1990 – 1992 онд Хууль зүйн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга
- 1992 – 1994 онд УИХ-ын дэргэдэх Төр, нийгэм судлалын академийн дэд захирал
- 1993 – 1997 онд Монголын Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч
- 1994 – 1996 онд Засгийн газрын дэргэдэх Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтын эрх зүйн тэнхимийн эрхлэгч
- 1994 – 1996 онд Засгийн газрын дэргэдэх Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтын эрх зүйн тэнхимийн эрхлэгч
- 1996 – 1998 онд Хууль зүйн сайд
- 1998 – 2016 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн, 2012 оноос цэцийн дарга
- 1999 – 2005 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн эрхлэгч
- 2002 – 2009 онд Хууль зүйн Үндэсний төвийн захирал
- 1998, 2005, 2011 онд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилогдсон.
- 2012–2016 онд Үндсэн хуулийн цэцийн дарга.
- 2016 оноос Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын зөвлөх

Монгол Улсын Их Сургуулийн Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн судалгааны төвийн зөвлөх профессороор ажиллаж байгаагаас гадна Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар байгуулагдсан Үндсэн хууль судлалын хүрээлэнд ажиллаж эрх зүйн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулсаар явна. Түүний Үндсэн хуулийн эрх зүй, үндэсний эрх зүйн тогтолцоог хөгжүүлэх чиглэлд оруулсан хувь нэмрийг үнэлж, Хөдөлмөрийн баатар, гавьяат хуульч Б.Чимидийн нэрэмжит шагналыг 2020 онд УИХ-аас олгосон билээ.

“Би 1971 онд МУИС-ийн оюутан болоод анхны хичээлээ Б.Чимид багшаар заалгаж байв. Дараа нь багшийнхаа удирдлага, зөвлөмжөөр олон жил сургалт, эрдэм шинжилгээний ажлыг хийж иржээ. Сургалт, эрдэм шинжилгээ, бүтээл туурвил бүрд багш маань надад зөвлөж, намайг чиглүүлж ирсэн. Мөн төрийн болон эрдэм шинжилгээ, сургалтын, олон нийтийн байгууллагад хамтран ажиллаж тэр хүний үр өгөөж, ивээл хайрыг хүртэж ирсэн. Өнөөдөр ч гэсэн бараг 50 дахь жилдээ Б.Чимид багшийнхаа ивээл, хайрыг хүртэж байгаадаа маш их баяртай байна” хэмээжээ.

Д.ЭНХЦЭЦЭГ:

“СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООГ ИЛҮҮ ХУВЬ ТЭНЦҮҮЛСЭН БОЛГОЖ, ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ”



нийгэмд өрнөж буй үйл явц харуулж байна. Сүүлийн хэдхэн жилийн хугацаанд гэхэд ардчиллаас ухарч, цэргийн дэглэмд шилжсэн, эрх чөлөөг эрмэлзсэн иргэдийнхээ эсэргүүцэл, дуу хоолойг нухчин дарж авторитарт тогтолцоог хүчлэн тулгасан улс орнууд хэд хэд байна.



Freedom House байгууллагын үнэлгээгээр 2021 онд Монгол Улс бүс нутагтаа цорын ганц эрх чөлөөт улс буюу ардчиллын баянбүрд хэвээр байгаа нь бидний хувьд бахархах зүйл мөн.

Нээлттэй нийгэм форум ТББ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Энхцэцэгтэй ярилцлаа.

–Бусдын нөлөөнд автахгүйгээр төр улсаа төвхнүүлэх эрх чөлөө Ази тивд хулигдах хандлагатай байгаа тухай таны ярьсныг уншсан. Яагаад ийм дүгнэлтэд хүрэв? Үнэхээр нөхцөл байдал тийм хүнд болсон уу, ямар судалгаанд үндэслэв?

–Цар тахлын эрсдэл нүүрлэсэн өнгөрсөн жилүүдэд иргэний болон улс төрийн эрхийг янз бүрийн хэлбэрээр хязгаарлах явдал нь “хэвийн үзэгдэл” мэт ойлгогдох болж, ийм хүлцэнгүй хандлагад дөрөөлөн иргэдийн оролцоог улам бүр боомилох үзэгдэл газар авч буй талаар ардчиллын асуудлаар тогтмол судалгаа хийдэг Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн тэргүүтэй олон улсын байгууллагууд анхааруулах болсон юм. Энэ чиг хандлагын тусгал манай бүс нутагт ч ажиглагдаж буйг сүүлийн жилүүдэд улс төр,

Сонгуулийн үр дүнд улс төрийн хүчнүүдийн хооронд эрх мэдлийн шилжилт тайван замаар явагдаж ирсэн нь манай ардчиллын амжилтыг илтгэж ирсэн нэг үзүүлэлт гарцаагүй мөн. Цар тахлын эрсдэл нүүрлэсэн жилүүдэд үндэсний хэмжээнд томоохон сонгуулийг хоёр жил дараалаад амжилттай зохион байгуулж чадлаа. Гэвч ардчилал бол байнга хянамгай анхаарч, сайжруулж засах зүйлээ засаж тордохгүй аваас гандаж доройтох нь амархан эрсдэлтэй болохыг бид олон жишээнээс үзэж мэдэрч байна. Энэ утгаараа, ялангуяа, төрийн легитим чанарын суурь болдог сонгуулийн хувьд үйл явц, үр дүнд итгэх иргэдийн итгэл сулрахаас сэргийлж, сонгуулийн үйл явцыг боловсронгуй болгох, ил тод, хяналттай байдлыг нэмэгдүүлэх, сонгогчдын саналын үнэ цэнийг алдагдуулахгүй байх сонгуулийн тогтолцооны шинэчлэлийг зоригтой хийх, сонгуулийн төв байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэх гэх мэт арга хэмжээг цаашид авах нь зүйтэй. Үүнийг хэрэгжүүлэхдээ

өнгөрсөн сонгуулиудын туршлагыг эргэн харж, алдаа, оноогоо бодитой үнэлж цэгнэн, олон талыг оролцуулан хэлэлцүүлэг өрнүүлж, судалгаа шинжилгээ баримт нотолгоонд үндэслэн хийх нь мөн чухал юм.

Сонгуулийн хууль тогтоомж дахин дахин өөрчлөгдөөд байна гэх шүүмжлэл гардаг л даа. Харьцангуй шинэ ардчилсан орны хувьд сонгуулийн үйл явцаа сайжруулж, боловсронгуй болгоход анхаарах нь уг нь байх л зүйл. Хамгийн гол нь аливаа өөрчлөлтийг улс төрийн явцуу эрх ашиг, сэдлээр биш зайлшгүй хэрэгцээ шаардлагад үндэслэн, олон талын оролцоотой зөвшилцөлд тулгуурлан, бодлого, шийдвэр гаргах үйл явцыг хуульчилсан хууль тогтоомжийн хүрээнд хийх нь чухал юм. Түүнээс бус сонгууль тулгаад хуулиа огцом огцом өөрчлөх нь мэдээж байж болохгүй асуудал. Манайд өмнө нь ийм зүйл гарч байсныг давтаж болохгүй алдаа гэж ойлгох нь зүйтэй.

-Иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг бүрэн дүүрэн хангахад юу дутагдаж байна гэж үздэг вэ?

-Өнгөрсөн хугацаанд УИХ дахь намууд сонгуулийн тогтолцоог байнга өөрчилж ирсэн нь сонгогчдын боловсрол, улс төрийн тэнцвэртэй шударга өрсөлдөөн, улс төрийн намын төлөвшилд сөргөөр нөлөөлж ирснийг судлаачид байнга шүүмжилдэг. Хамгийн сүүлд 2020 оны УИХ-ын сонгуулийг томсгосон тойргууд бүхий мажоритар тогтолцоогоор зохион байгуулсан. Мажоритар тогтолцооны онцлогоос шалтгаалж, нийт хүчинтэй саналын 44.9 хувийг авсан МАН УИХ-д 62 суудалтай (81.6%) болсон. Нийт хүчинтэй саналын 55.1 хувийг авсан бусад намын зүгээс сонгуулийн дараа нэлээд маргаан өрнүүлж, улс төрийн зарим хүчин сонгуулийн дүнд эргэлзсэн мэдэгдэл хүртэл гаргаж байсан нь цаашид сонгуулийн тогтолцоог илүү хувь тэнцүүлсэн болгож, шинэчлэх шаардлага байгааг харуулж байна.

Сонгуулийн тогтолцоотой холбоотой нэлээд маргаан дагуулсан бас нэг асуудал нь тойрогт оногдох мандатын тоо байдаг. Ардчилсан сонгуулийн тэгш эрхийн зарчим хэрэгжих нэг нөхцөл нь “нэг сонгогч нэг санал өгөх” шаардлага, түүнчлэн сонгогчдын саналын жин тэгш байх явдал юм. Саналын жин тэнцвэртэй байхын тулд тойрог дахь сонгогчдын

тоог харьцангуй тэгш байхаар тогтоох учиртай. 2020 оны УИХ-ын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтад нийт 2,003,969 сонгогч бүртгэгдсэн байсан. Мажоритар тогтолцоонд тойрогт ногдох мандатын тоог сонгогчдын тоог харгалзан эн тэнцүү байхаар төгс хуваарилалт хийх боломжгүй. Гэсэн хэдий ч нэг мандатад ногдох сонгогчдын тоо орон даяар 16,552-оос 54,035-ын хооронд хэлбэлзэж байсан нь нэлээд шүүмжлэл дагуулж байв. Цаашид сонгуулийн тойргийг байгуулах, тойрогт ногдох мандатын тоог тогтоохдоо эрх баригч улс төрийн хүчин дангаараа шийдвэр гаргах бус сөрөг хүчин болоод бусад талтай зөвшилцөн шийддэг болох нь шударга сонгуулийн зарчимд илүү нийцнэ.

Сонгуулийн үйл явцтай холбоотой өнөөг хүртэл шийдэгдэхгүй ужгирч ирсэн нэг асуудал нь өрсөлдөөний гараа тэгш бус байсаар ирсэн явдал бөгөөд энэ нь сонгуулийн санхүүжилттэй шууд холбоотой юм. Кампанит ажлын зардал сонгуулиас сонгуульд огцом нэмэгдэж ирсэн ба сонгуульд санхүүгийн боломж ихтэй нам, нэр дэвшигч давамгайлахын зэрэгцээ санал худалдан авах зөрчил байнга гаргадаг ч өнөөг хүртэл дорвитой тэмцэж чадахгүй байна. Цаашид сонгуульд тэгш өрсөлдөх нөхцөлийг сайжруулахын тулд сонгуулийн зардлыг аль болох бууруулах арга хэмжээ авах, санхүүжилтийн ил тод байдал, хяналтыг нэмэгдүүлэх, эрх баригч хүчний зүгээс төрийн нөөц хөрөнгийг улс төрийн зорилгоор ашиглах байдлыг хянах, сонгуулийн санхүүжилтэд нэр дэвшигчдийн хувийн болон хуулийн этгээдийн хандив аль болох бага, харин сонгогч дэмжигчдийн хандив болон төрийн санхүүжилт аль болох түлхүү хувь эзлэхээр зохицуулах гэх мэт цогц арга хэмжээ нь авах нь зүйтэй.

Манайд сонгогчдын нэрийн жагсаалт болон санал тоолох үйл явцыг автоматжуулах эрх зүйн орчныг 2011 онд бүрдүүлж, улмаар 2012 оны УИХ-ын сонгуулиас хойш хэрэгжүүлж ирлээ. Гэвч санал тоолох автомат төхөөрөмж болон сонгогчдын нэрийн жагсаалтад үл итгэх байдал ажиглагдсан хэвээр байна. Санал тоолох төхөөрөмжийн хувьд нам, ажиглагчдын зүгээс тавих хяналтыг нэмэгдүүлж, ил тод байдлыг хангахад чиглэсэн тодорхой арга хэмжээ авч ирсэн нь үр дүнгээ өгнө гэж найдаж байна. Харин сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой

санал, гомдол 2016 оны УИХ-ын сонгуулиас хойш нэлээд гарах болсон ба энэ асуудалд зайлшгүй анхаарал хандуулах шаардлагатай байна. Өнгөрсөн хэд хэдэн сонгуулийн үеэр Сонгогчдын боловсрол төвийн ажиллуулсан сонгогчдод зөвлөгөө өгөх лавлах утсанд ирсэн гомдол, саналын бараг талаас илүү хувь нь сонгогчийн хаягт сонгогч илүү, эсхүл дутуу бүртгэгдсэн талаар байсныг тус байгууллагаас мэдээлж байв.



Сүүлийн жилүүдэд цахим орчноор мэдээлэл дамжих хурд асар их нэмэгдэж, үүнтэй зэрэгцэн сонгуулийн үйл явц, үр дүнд тусах нөлөө нь ч тэлж байна. Энэ бол зөвхөн манайд төдийгүй олон улсад шийдэл нь тодорхой бүс байгаа нэг асуудал болж байна.

Энэ мэт шинэ тутам үүссэн болон өнөөг хүртэл шийдэж чадахгүй байгаа асуудлууд байгааг бодлого боловсруулагчид анхаарах байх гэж найдаж байна.

-Сонгуулийн насны иргэдийн идэвх, оролцоо анхаарал татсан асуудал болох янзандаа орчихлоо. Энэ юутай холбоотой бол?

-Сонгуулийн ирцийн олон улсын дундажтай харьцуулахад манай сонгогчид сонгуульдаа харьцангуй идэвхтэй оролцдог. Гэсэн хэдий ч сонгуулийн ирц ерөнхийдөө буурах хандлагатай байж ирсэн ба хамгийн сүүлд болсон Ерөнхийлөгчийн сонгуулиар анх удаа ирц 60 хувиас доош бууж суларсан. Ерөнхийлөгчийн сонгуулиар гадаадад байгаа сонгогчид сонгуульд оролцож санал өгөх бололцоог хуулиар нээж өгсөн ч зохион байгуулалтын хувьд бэрхшээл их байгаагаас оролцох боломж нь бодит байдалд маш тааруу байсныг сонгуульд ажиглалт хийсэн иргэний нийгмийн байгууллагууд тайландаа дурдсан байдаг. Тухайлбал, 122 мянган сонгуулийн насны иргэн байгаагаас 7394 сонгогч буюу 6.6 хувь оролцохоор бүртгүүлсэн бөгөөд үүнээс 76 хувь нь буюу 5618 буюу нийт гадаадад байгаа сонгогчдын 4.6 хувь нь л саналаа өгсөн байна.

Манай нийт сонгогчдын бараг тал шахам нь 20-39 насны залуу сонгогч байгаа статистик мэдээлэл байдаг. Энэ насны сонгогчдын идэвх маш тааруу байгааг мөн сүүлийн жилүүдэд нэлээд ярьж хэлэлцэж байна. Төрийн удирдлага, засаглалын академи зэрэг зарим байгууллагын энэ асуудлаар хийсэн судалгааны дүнг харахад залуу сонгогчдын хувьд итгэл хүлээсэн нам, улс төрч байхгүй, улс төрд итгэдэггүй, улс төр сонирхдоггүй учир сонгуульд оролцдоггүй, сонгууль нь тодорхой өөрчлөлт, ахиц дэвшил авчирна гэсэн найдвар төрөхгүй байна гэх мэт шалтгаан дурдсан байгаа нь анхаарал татаж байна. Тэгэхээр сонгогчдын ирцийг нэмэгдүүлэхийн тулд хуульд шаардлагатай өөрчлөлтүүдийг тусгахаас гадна намуудын зүгээс мөн анхаарал хандуулж сонгуулийн арга барилаа өөрчлөхгүй бол цаашид сонгуулийн ирц улам буурах вий гэж санаа зовж байна.

-Шударга сонгууль, сонгуулийн зохион байгуулалтын асуудлаар судалгаа явуулж, асуудал хөндсөн байсан. Сонгуулийн төв байгууллага иргэний нийгмийн хамтын ажиллагааг Та хэрхэн төсөөлдөг вэ? Ялангуяа сонгогчийн боловсролын чиглэлээр ямар ахиц гаргах шаардлагатай юм бол?

-Ардчилсан сонгуулийн тулгуур зарчмын нэг нь сонгуулийн үйл явцын ил тод байдал бөгөөд сонгуульд иргэний нийгмийн зүгээс идэвхтэй хяналт тавих нь ил тод байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгээд зогсохгүй сонгуулийн үйл явц, үр дүнд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлж аливаа маргаан, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой байдаг. Сонгуульд хяналт мониторинг тавих чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд нэгдэн Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээг 2008 онд байгуулсан ба энэ сүлжээ нь Сонгуулийн Ерөнхий Хороотой өнөөг хүртэл тасралтгүй хамтран ажиллаж Монгол Улсын ардчилсан сонгуулийн нэр хүндийг бүс нутагтаа болоод олон улсад өргөхөд тодорхой хувь нэмрээ оруулж ирлээ.

Сүлжээний иргэний нийгмийн ажиглагчид сонгуульд ажиглагчаар оролцох эрх нь хуулиар баталгаажсан цагаас хойш буюу 2012 оны УИХ-ын сонгуулиас эхлэн сонгуулийн ажиглалтыг тасралтгүй зохион байгуулсан ба өнөөг хүртэл

давхардсан тоогоор 900 орчим залууст ажиглагч хийн сонгуулийн боловсролоо нэмэх бололцоог нээж өгсөн байна.



Сонгуулийн ажиглалт хийхэд залуусыг татан оролцуулах нь тэдэнд сонгуулийн хууль тогтоомж, чөлөөт шударга сонгуулийн олон улсын стандартуудыг танилцуулж, ардчилсан улсын иргэний хувьд улс төрийн чухал үйл явцад идэвхтэй оролцох, сонгогчийн боловсролыг нэмэгдүүлэх давхар ач холбогдолтой байдаг.

Санал хураах үйл явц хуулийн дагуу явагдсан ч зохион байгуулалтын алдаанаас үүдэлтэй хардлага, маргаан нь зарим нөхцөлд сонгуулийн үр дүнд итгэх олон нийтийн итгэлийг бууруулж, улмаар ноцтой үр дагаварт хүргэх эрсдэлтэйг гадаад, дотоодын олон жишээнээс харж болно. Ийм нөхцөл байдал үүсэхээс сэргийлэхэд иргэний нийгмийн хөндлөнгийн хяналт чухал байдаг.

Ярилцсан Д.Бадмаараг





Докторант С.Оюунтуяа

“Сонгогчдын боловсрол төв”
ТББ-ийн гүйцэтгэх захирал

С.ОЮУНТУЯА

СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАРААТ БУС БАЙДАЛ, ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

1 Сонгуулийн удирдлагын байгууллагын хэлбэрүүд, хөгжлийн чиг хандлага

Сонгуулийг эрхлэн зохион байгуулах үүрэг бүхий сонгуулийн байгууллага нь улс төрийн нөлөө, сонирхлоос ангид байж, хараат бусаар үйл ажиллагаа явуулах нь ардчилал шинээр тогтоосон улсуудын хувьд амин чухал асуудал болж байгаа хэвээр байна. Гэхдээ “бие даасан, хараат бус байдал” гэдэгт чухам юуг хэлэх талаар нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхой үзэл баримтлал байдаггүй. Яагаад гэвэл “бие даасан” гэдэг нэр томъёо нь нэг талаас “бүтцийн”, нөгөө талаас “хэм хэмжээний” тухай ойлголтыг хамтад нь агуулах бөгөөд бүтцийн хувьд засгийн газраас хараат бус байх, хэм хэмжээний хувьд аливаа шийдвэр гаргахдаа засгийн газар, улс төрийн нам, бусад байгууллагын нөлөөнд автахгүй байх тухай юм. Бүтцийн бие даасан байдал нь тухайн улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор баталгааждаг бол харин хэм хэмжээний буюу шийдвэр, үйл ажиллагааны бие даасан байдлыг зохих хууль тогтоомжид суулгаж өгөх явдал байдаг. Гэхдээ ихэнх улс орнуудад бүтцийн бие даасан байдлаас илүү сонгуулийн удирдлагын байгууллагын болон гишүүний бие даасан үйл ажиллагаа, бие даан шийдвэр гаргах чадавхыг чухалчилдаг байна.

Дэлхийн улс орнууд хөгжлийн дээрх чиг хандлагад үндэслэж улс төрийн сонирхол, нөлөөллөөс ангид байх хувилбарыг аль болох сонгон авахыг чармайдаг. Дэлхийн улс орнуудын сонгуулийн удирдлагын байгууллагуудыг харьцуулан үзвэл “бие даасан”, “төрийн”, “холимог” гэсэн гурван үндсэн бүлэгт хувааж үзэж болохоор байна.¹⁰

Төрийн бөгөөд улс төрийн алба нь салангид, төрийн алба нь улс төрөөс хараат бус соёл төлөвшсөн, ардчилал өндөр хөгжсөн зарим улсад төрийн байгууллага сонгуулийг зохион байгуулдаг загвар байна. Тухайлбал, ХБНГУ үүний сонгодог жишээ юм. Харин ардчилалд шилжиж байгаа улс орнуудад ийм хувилбар төдийлөн тохирохгүй учраас төрөөс аль болох тусдаа бие даасан байгууллага сонгуулийн үйл явцыг эрхлэн, зохион байгуулах ёстой гэсэн хандлага олон улсад давамгайлж байна.¹¹ Холимог

¹⁰ Election Management Design: The International IDEA handbook. International Institute for Democracy and Electoral Assistance. 2006.p.8. Тус байгууллагын 2006 онд дэлхийн 214 улсын сонгуулийн загваруудыг харьцуулан судалсан бөгөөд тэдгээрээс 55 хувь нь бие даасан, 26 хувь нь төрийн, 15 хувь нь холимог загвартай байна.

¹¹ Establishing independent electoral bodies; their tasks and responsibilities. www.idea.org, Guiding principles of Electoral Management. <http://aceproject.org/ace-en/topics/em/em/20>



хувилбар бол төрийн байгууллагад сонгууль зохион байгуулах эрхийг олгоод сонгуулийн бие даасан байгууллага нь түүнд хяналт тавьдаг. Энэ холимог загвар нь Франц, Япон, Испани, Латин Америкт түгээмэл хэрэглэгддэг бөгөөд Англи улс 2000 оноос хойш ашиглаж байгаа юм байна.¹²



Сонгуулийн байгууллагуудын дээрх бүлгүүдээс хамгийн түгээмэл нь төрөөс аль болох тусдаа бие даасан байгууллагад сонгуулийн удирдлага, зохион байгуулалтыг хариуцуулж байгаа бөгөөд¹³ бүтэц болон бүрэлдэхүүнээс нь хамааран "улс төрийн намын төлөөллөөс бүрдсэн", "мэргэжилтнүүдээс бүрдсэн" хоёр янз байдаг.

Манайхтай төстэй хуучин социалист орнуудад шилжилтийн эхний үед гишүүд нь бие биенээ хянах боломжтой олон намын төлөөллөөс бүрдсэн бие даасан хороод байгуулан сонгуулийг зохион байгуулах ажлыг хариуцуулсан ба шилжилтийн үед сонгуулийн үйл явц болоод үр дүнд итгэх улс төрийн нам, нэр дэвшигчид, сонгогчид болон бусад оролцогч талын итгэл нэмэгдэхийн хэрээр бие даасан, өндөр мэдлэг чадвар бүхий мэргэжилтнүүдээс бүрдсэн байгууллага болгож өөрчлөх хандлага ажиглагдаж байна.¹⁴

Бие даасан хэлбэрийн байгууллагуудад байдаг хараат бус байдлаа хамгаалахад чиглэсэн хамгийн түгээмэл хоёр зүйл байна. Үүнд,

- Бүрэлдэхүүний хувьд төрийн, ялангуяа гүйцэтгэх эрх мэдлийн албан тушаалтнуудыг хамааруулдаггүй. Харин олон нийтэд нэр хүндтэй, улс төрийн хувьд төвийг сахиж

¹² Election Management Design: The International IDEA handbook. International Institute for Democracy and Electoral Assistance. 2006.p.82.

¹³ Ийм улс орнуудад Австрали, Польш, Тайланд, Канад, Эстон, Гүрж, Энэтхэг зэрэг ордог.

¹⁴ Д.Энхцэцэг, Сонгуулийн зохион байгуулалтын зарим асуудалд, бодлогын цуврал. 8 дахь тал. 2010 он

чадах голч байр суурьтай, хуульч, улс төр судлаач мэргэжилтэй хүмүүсээс голчлон бүрдүүлдэг. Иймд эдгээр шалгууруудыг хуульд нарийвчлан тусгаж өгдөг. Бусад улс орнуудыг ажиглахад шүүгч, их сургуулийн багш, профессорууд түгээмэл байдаг. Тухайлбал, Испанид сонгуулийн төв байгууллагын 13 гишүүний 8 нь дээд шүүхийн шүүгч, 5 нь улс төр, социологи, хуулиар мэргэшсэн их сургуулийн багш нар байдаг.¹⁵

- Сонгуулийн байгууллагын төсөв нь сонгуулийг зохион байгуулахад хангалттай байхын зэрэгцээ гүйцэтгэх эрх мэдлээс бие даасан байдаг. Энд сонгуулийн байгууллагын гишүүний хараат бус байдлыг хангах хэмжээний цалин, урамшууллыг багтаадаг. Зарим улсад сонгуулийн байгууллагаас өргөн барьсан төсвийг үндэслэлгүйгээр танаж, өөрчлөх ёсгүй гэдэг зарчмыг Үндсэн хуульд хүртэл суулгаж өгсөн байдаг байна.

Улс төрийн намын төлөөллөөс бүрдсэн бие даасан сонгуулийн хороо нь улс төрийн намын томилгоогоор бий болох бөгөөд зөвхөн парламентад суудалтай намуудаас бүрэлдэх, эсвэл олонх болсон нам, сөрөг хүчин, эсвэл парламентын гадна байгаа намууд зөвшилцөх эсэх зэргийг хуулиар тогтоодог. Нэгэнт улс төрийн намаас томилогдсон гишүүд намынхаа эрх ашгийг хамгаалах болдог утгаараа төвийг сахих зарчим болон хараат бус, бие даасан байдалд эргэлзээ бий болдог. Хэдийгээр намаас томилогдож байгаа нь тухайн намын төлөө ажиллана гэсэн амлалт биш ч улс төрийн намын чухал эрх ашиг хөндөгдөж байдаг утгаараа шийдвэр гаргах үйл явц гажуудахад хүрдэг. Ардчилсан тогтолцоонд шилжих шилжилтийн эхний шатуудад улс төрийн намын төлөөлөл бүхий байгууллага нь олон нийтийн итгэлийг бий болгох, ил тод байдлыг нэмэгдүүлэх, асуудлыг зөвшилцөх аргаар шийдвэрлэх боломжийг олгодог давуу талтай байна.

Мэргэжилтнүүдэд суурилсан сонгуулийн удирдлагын байгууллагыг нам бус гэж нэрлэдэг. Ийм байгууллагыг улс төрийн намууд, эсвэл иргэний нийгмийн байгууллагууд томилж болдог.



Мэргэжилтнүүдэд суурилсан сонгуулийн байгууллагын гишүүн байх шалгуурт улс төрийн хувьд төвийг сахих зарчим, насны доод хязгаар, мэргэжлийн үр чадвар, сонгуулийн талаарх мэдлэг зэрэг орно.

Гишүүд нь гол төлөв хууль эрх зүй, төрийн удирдлага, улс төрийн шинжлэх ухаан, хэвлэл, мэдээлэл зүйн салбарт мэдлэг туршлагатай, төвийг сахих чадвар нь олон нийтэд танигдсан хүмүүс байдаг. Ийм байгууллагад Австрали, Бангладеш, Канад, Коста Рика, Энэтхэг, Польш, Тайланд, Украин улс ордог. Эдгээр улсын хууль тогтоомжид улс төрийн намын үйл ажиллагаанд оролцож байгаагүй хүнийг томилж ажиллуулахаар заасан байна¹⁶.

2

Сонгуулийн удирдлагын байгууллагын гишүүнийг сонгох шалгуур, чиг хандлага




Олон улс орнуудад сонгуулийн байгууллагын гишүүнээр сонгуулийн нарийн төвөгтэй үйл явцыг төвийг сахих зарчмын үндсэн дээр зохион байгуулах арга барил эзэмшсэн зохих мэргэжлийн хүмүүсийг сонгон шалгаруулах замаар ажиллуулж чадвал сонгуулийн байгууллагад итгэх олон нийтийн итгэл бэхжинэ гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Сонгуулийн удирдлагын байгууллагын гишүүнд тавигдах шалгуур нь улс төрийн намын тогтолцоо, мэргэжилтэнд сууриалсан тогтолцоо байна уу гэдгээс илүүтэй хамаардаг байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн намын тогтолцоонд суурилсан байгууллага бол хэн байх, ямар шалгуур байх гэдгийг улс төрийн нам өөрсдөө тогтоодог. Гэхдээ заавал үндэслэх, хуульд оруулах шалгуурт төвийг сахиж хараат бус үйл ажиллагаа явуулж чадах, ажил үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэх, мэргэжлийн үр чадвартай байх явдал багтдаг. Улс орнуудад сонгуулийн удирдлагын байгууллагын гишүүнд

¹⁵ Election Management Design: The International IDEA handbook. International Institute for Democracy and Electoral Assistance. 2006.p.9.

¹⁶ Election Management Design: The International IDEA handbook. International Institute for Democracy and Electoral Assistance. 2006.p.119.

тавих шалгуур бас өөр өөр байгаа ч хамгийн нийтлэг нь мэргэжлийн ур чадвар, төвийг сахих зарчмыг чанд мөрдөж ажиллах юм. Зарим улсад мэргэжлийн ур чадварт эрх зүйн мэргэжил, туршлага голлох үүрэгтэй байгаа бол дарга нарын хувьд шүүгч, эсвэл өмнө нь шүүгчээр ажиллаж байсан, эсвэл ийм албан тушаалд тохирох хүн байх ёстой гэдэг шалгуур тавьдаг. Орос улсад гишүүд нь эрдмийн зэрэг

цолтой хуульч, эсвэл их сургуулиар хуулийн мэргэжил эзэмшсэн хүн байх ёстой гэдэг, Литва, Тайландад наад зах нь их сургууль төгссөн байх ёстой гэдэг. Бусад тусгай шалгуурт иргэний харьяалал буюу заавал тухайн улсын иргэн байх, насны дээд болон доод хязгаарыг тогтоох зэрэг орж байна. Доор мэргэжилтнүүдэд суурилсан байгууллагын гишүүдэд тавигддаг нийтлэг шалгуурыг харуулав.





3 Сонгуулийн удирдлагын байгууллагын гишүүдийг шилж сонгох, томилох

Сонгуулийн удирдлагын байгууллагын гишүүдийг шилж сонгох, томилох асуудлыг хуулиар нэг мөр зохицуулдаг. Дэлхийн улс орнуудад сонгуулийн байгууллагын гишүүдийг төрийн тэргүүн, гүйцэтгэх засаглал, шүүгч, улс төрийн нам томилдог өргөн хүрээтэй, өөр хоорондоо ялгаатай зохицуулалтууд байна. Ингэхдээ шилж сонгон шалгаруулах ажлыг тодорхой тооны нэр дэвшигчдийн дотроос хаалттай, эсвэл нээлттэй сонгон шалгаруулах аргаар нэрдэвшигчдийн нурчадвар, үнэнчшударга байдалд үнэлгээ хийх замаар томилж байна¹⁷. Өмнөд Африк, Намиби зэрэг мэргэжилтнүүдэд суурилсан сонгуулийн байгууллагатай улсад нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар томилдог.

Сонгуулийн байгууллагын гишүүнийг, ялангуяа мэргэжилтэнд суурилсан байгууллагын хувьд төрийн тэргүүн санаачилж, хууль тогтоох байгууллагаар батлуулдаг жишиг нэлээд их байдаг. Тухайлбал, Кени, Сьерра Леон зэрэг. Харин Индонезид төрийн тэргүүн нэг гишүүнд хоёр хүний нэрийг санал болгон хууль тогтоох байгууллагад оруулах бөгөөд хууль тогтоох байгууллага нь уг хоёр хүнээс амаар болон бичгээр шалгалт авч хамгийн өндөр оноотой хүнийг томилуулахаар төрийн тэргүүнд илгээдэг байна. Харин зарим оронд тухайлбал, Их Британийн бүрэлдэхүүнд байсан Фижи, Сент

¹⁷ Election Management Design: The International IDEA handbook. International Institute for Democracy and Electoral Assistance. 2006.p.118.



Ганц саналын зөрөө л Танд улс төрийн ямар нам, нэр дэвшигчийг дэмжиж, хэнээр жолоодуулан үйлчлүүлэхийг шийднэ шүү дээ.

Б.ЧИМИД

Луси зэрэг улсад гишүүдийг ерөнхий сайдын зөвлөснөөр сөрөг хүчинтэй зөвшилцсөний үндсэн дээр төрийн тэргүүн томилдог. Ийнхүү сонгуулийн байгууллагын гишүүнийг томилох эрх мэдлийг гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагын хооронд хуваарилах нь томилох үйл явцын хяналттай, тэнцвэртэй байдлыг хангах зорилготой. Гэвч энд нэг нам дангаар байгаа үед дээрх зорилгыг хангаж чадахгүй бөгөөд энэ тохиолдолд томилох үйл явцыг парламентын гишүүдийн гуравны хоёрын саналаар батлах нь хараат бус, бие даасан байдалд эерэгээр нөлөөлнө гэж шинжээчид үздэг байна. Хөгжлийн сүүлийн үеийн чиг хандлага бол энэхүү томилох үйл явцад иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагын хөндлөнгийн оролцоог бий болгохыг чухалчилдаг болсон, түүнчлэн томилохдоо парламентад маш өргөн хүрээний оролцоог хамарсан нээлттэй сонгогч явуулах замаар томилох туршлага нэлээд газар авч байна.

4 Сонгуулийн удирдлагын байгууллагуудын гишүүдийн хараат бус, бие даасан байдлын баталгаа

Ихэнх улс орнуудад сонгуулийн удирдлагын байгууллагын гишүүний хараат бус, бие даасан байдлын баталгааг хуулиар тогтоодог. Тухайлбал, цалинг хасах, ажлын нөхцөл, хангамж, үйлчилгээг бууруулах, шүүхэд татах, гүйцэтгэх засаглал болон бусад байгууллагын зүгээс ажлыг нь өөрчлөхөөс хамгаалснаар гишүүнийг төвийг сахих зарчмыг баримтлан

мэргэжлийн өндөр түвшинд хэн нэгнээс айхгүй, хэн нэгний дарамт шахалтад өртөхгүйгээр ажил үүргээ гүйцэтгэх боломж олгодог. Ямар ч тохиолдолд өөрийг нь томилсон байгууллагаас хараат бус байж, тэднийг төлөөлөхгүй, тэдэнд тайлагнахгүй байх тодорхой заалтууд хуульд туссан байдаг.

Гишүүдийг гэмт хэрэг үйлдсэн, биеийн болон сэтгэцийн хувьд хөдөлмөрлөх чадвараа алдсан тохиолдолд ажлаас чөлөөлөхийг зөвшөөрдөг. Тухайлбал, Энэтхэгт гишүүн нь гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон ч хууль тогтоох байгууллагын гишүүдийн гуравны хоёрын саналаар л түүнийг ажлаас нь чөлөөлдөг байна. Ихэнх улс орны сонгуулийн байгууллагын гишүүд урамшуулал, ажлын хөлс авдаг бөгөөд хэмжээ нь үйл ажиллагаагаа хараат бус явуулах баталгаа болохуйц байдаг.

5 Сонгуулийн удирдлагын байгууллагын гишүүдийн тоо

Ихэнх улс орнуудад энэ тоо ялгаатай ч голдуу хуулиар тогтоосон байдаг. Гишүүдийн тоо хэд байх нь газар нутгийн хэмжээ, засаглалын хөгжил, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал зэргээс хамаарахгүй ч улс төрийн намуудын төлөөллөөс бүрддэг сонгуулийн байгууллагуудын тоо олон, харин экспертэд тулгуурласан байгууллагын гишүүдийн тоо цөөн байдаг. Тухайлбал, Лесото зэрэг жижиг улсад 3 гишүүнтэй байхад хавьгүй том нутаг дэвсгэртэй Нигерид 13, асар том нутаг дэвсгэртэй Канад, 600 сая сонгогчтой Энэтхэгт дөнгөж 3 гишүүнтэй байна.

Сонгуулийн байгууллагын гишүүдийн тоо сондгой байх нь байгууллагын даргад давуу эрх олгохгүй байх сайн талтай. Ерөнхийдөө гишүүдийн тоо хэт олон байх нь өргөн хүрээний төлөөллийг бий болгох сайн талтай бол, цөөн тохиолдолд асуудлыг богино хугацаанд хэлэлцэн шийдвэр гаргахад хялбар болно.

6 Сонгуулийн удирдлагын байгууллагын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа

Сонгуулийн удирдлагын байгууллагын гишүүний бүрэн эрхийн хугацаа нь мөн харилцан адилгүй байдаг. Тухайлбал, Пакистанд 3 жил, Латви, Гондурас зэрэг улсад дөрвөн жил, Босни Герцеговина, Фижи зэрэгт таван жил, Гүрж болон Туркд зургаан жил, Мексик, Өмнөд Африкт долоон жил, Румынд найман жил, Ботсванад 10 жил байдаг байна¹⁸. Харин зарим улсад гишүүдийнхээ бүрэн эрхийн хугацааг тогтоодоггүй, нэгэнт томилогдсон бол халагдаж, чөлөөлөгдөөгүй л бол тэтгэврийн нас хүртлээ ажиллаж болдог.

Бүрэн эрхийн хугацааг хязгаартай тогтоохын давуу талыг шинэ томилолт хийх замаар шинэчлэл хийх ач холбогдолтой гэж үздэг бөгөөд харин парламентын сонгуулийн бүрэн эрхийн хугацаатай адил байх нь хараат бус, бие даасан байдлаар ажиллах болон байгууллагын туршлагыг уламжлан авч үлдэхэд эрсдэл бий болгох талтай. Гишүүд хоёр жил тутамд хэсэгчлэн шинэчлэгдэж байхаар тогтоодог улс орнууд нэлээд элбэг байдаг.



СОНГУУЛИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГЫН ГИШҮҮДИЙН ТОО

3

ЛЕСОТО

13

НИГЕРИ

3

КАНАД

600 сая
ЭНЭТХЭГ



¹⁸ 2005 оны байдлаар

Activity of company and subdivisions

Data and prognosis of activity



UIH.MN
СУДАЛГААНЫСАН

4

СУДАЛГАА

- Залуу сонгогчдын ирц, оролцоог нэмэгдүүлэх нь
- Сонгуулийн сурталчилгааны үеэр түгээсэн мэдээллийн мониторинг

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

41

Б.ЭРДЭНЭДАЛАЙ

ЗАЛУУ СОНГОГЧДЫН ИРЦ, ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Ардчилсан нийгмийн гол шинж нь чөлөөт, шударга сонгууль бөгөөд сонгууль нь иргэдийн хувьд төрөө байгуулах, төрийн хэргийг хөтлөн явуулахад оролцож буй нэн хариуцлагатай, онцгой үйл ажиллагаа. Ардчиллын тухай онолын дагуу төрийн эрх мэдэл ард түмнээс үүдэлтэй ба ард түмний бүрэн эрхт байдал, олонхын удирдлагын үзэл санааг хэрэгжүүлэх гол хэрэгсэл бол сонгууль юм.

Ардчилсан сонгууль нь бүх нийтийн, чөлөөтэй сонгох, шууд сонгох, саналаа нууцаар гаргах, тэгш эрхийн гэсэн үндсэн зарчмуудыг баримталдаг. Тухайлбал, **бүх нийтийн зарчим** нь тухайн улсын сонгуулийн насанд хүрсэн, эрх бүхий (эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, хорих болон баривчлах ял эдэлж байгаагаас бусад) нийт иргэн сонгуульд өргөнөөр оролцож, саналаа илэрхийлэх боломж гэж үздэг.

Сонгуулийн бас нэгэн чухал зарчим бол **чөлөөтэй сонгох зарчим** бөгөөд энэ нь сонгуульд оролцох, эс оролцох, хэний ч дарамт шахалтад оролгүйгээр саналаа чөлөөтэй илэрхийлэх, нэр дэвшигчдээс бүгдийг татгалзах, сонголт хийх боломжтой байхыг хэлнэ.

Санал бол төрийн эрхийг барихад оролцож буй эрх мэдэл юм. Ийм учраас сонгуульд оролцож саналаа өгдөггүй хувь хүн, бүлгийн эрх ашиг хохирч болзошгүй. Сонгуулийн мажоритар буюу дийлэнх олонхын системийг ашиглаж байгаа бол тухайн тойрогт хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг парламентийн гишүүнээр сонгогдсонд тооцдог. Энэ тохиолдолд сонгогчдын санал ихээр гээгдэж, сонгуулийн үр дүн цөөхөн саналын зөрүүгээр шийдэгддэг. Парламентад нийт сонгогчдын төлөөллийг бүрэн төлөөлж чадахгүй байх энэ нөхцлийг сонгуульд саналаа өгдөггүй, сонгуулийг үл ойшоодог иргэдийн үйлдэл мөн өөгшүүлж байна.



Доктор Б.Эрдэнэдалай


МУИС-ийн Улс төр судлалын
тэнхимийн ахлах багш

Дэлхий дахинд сонгуулийн оролцооны бууралтын байдал ажиглагддаг. Гэхдээ сонгуулийн ирц буурч буй байдлыг хүлээн зөвшөөрч иргэдийн сонгуульд оролцох идэвхийг нэмэгдүүлэхгүй бол тухайн орны ардчилалд ухралт болж, цөөхөн саналын зөрүүгээр ялалт байгуулах, эсвэл шударга бус, ёс суртахуунгүй улс төрчид гарах нөхцлийг бүрдүүлдэг. Сонгуулийн санал хураалтад сонгогчид оролцохоос зайлсхийсэн улс төрийн энэ үзэгдлийг абсентеизм гэсэн нэр томъёогоор тэмдэглэдэг. Иргэд янз бүрийн шалтгаанаар сонгуульд оролцдоггүй. Улс төрийг огт сонирхдоггүй нэг хэсэг байхад, амлалтад үл итгэх хүмүүс олон байдаг. Абсентеизмтай тэмцэх оролдлогыг олон оронд хийдэг. Австри, Бельги, Голланд, Латин Америкийн орнуудад сонгуульд иргэдийг зайлшгүй оролцохыг албан ёсоор

шаарддаг. Сонгуульд оролцоогүй тохиолдолд торгууль ноогдуулж, үйл ажиллагаанд нь хязгаарлалт хийж, төрийн алба хаах эрхийг хязгаарладаг байна. Зарим улсад санал өгөхөөс

зайлсхийсэн иргэнийг 4 долоо хоног шоронд хорьдог байжээ. Эдгээр оронд сонгуульд санал өгөх нь иргэний хариуцлагатай, чухал үүрэг гэж үздэг.

▼ **Зураг 1. Дэлхийн зарим улсуудын парламентийн сонгуулийн ирц**



Эх сурвалж: IDEA. Voter Turnout Analyzer.


<http://www.idea.int/vt/analyzer/index.cfm#ps&m=2&f=0&t=0&tm=0&ts=19452016&g=c47,c61,c114,c122,c147,c191,c231&r=0&c=0>

Дээрх зургаас дэлхийн улс орнуудын сонгуульд оролцож, саналаа өгч байгаа сонгогчдын хувь буурч байгаа нь харагдаж байна.

Ерөнхийдөө нийт сонгуульд оролцогчдын хувь буурч байгаа ч насны бүлгээр сонгуульд оролцож, саналаа өгөх байдал 34 хүртэлх насны залуучуудын хувьд хамгийн бага үзүүлэлттэй байдаг тул дэлхийн улс орнууд үүнд анхаарал хандуулж, залуучуудын ардчилал, сонгуулийн талаарх мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх, саналаа өгөхийн ач холбогдлыг таниулж, уриалж, дэмжсэн олон төрлийн үйл ажиллагааг явуулдаг байна.

Монгол Улс 1992 оноос хойш нийт УИХ-ын найман удаагийн сонгуулийг зохион байгуулжээ. 1992 оны сонгуульд сонгуулийн насны иргэдийн 95.6 хувь нь сонгох эрхээ эдэлж байсан ч 10 жилийн дараа 67.24 хувь болж огцом буурсан бол 2016 оны УИХ-ын сонгуулийн ирц 74.35 хувь болж өмнөх сонгуулиас бага зэрэг өссөн ч 2020 онд 73.6 хувь болжээ. Дараах зурагт ардчилсан сонгуулиудын ирцийн дүнг харьцуулан гаргалаа.

▼ Зураг 2. УИХ-ын сонгуулийн ирц



Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хорооны сайт дээрх сонгуулийн дүнгүүдээс нэгтгэв.

Судалгааны байгууллагуудын судалгаанаас харахад, сонгогчдын 70-80 орчим хувь нь сонгуульд оролцоно гэж хариулдаг боловч бодит байдал дээр 50 орчим хувь нь саналаа өгдөг нь иргэдийн улс төрийн болон сонгуулийн боловсрол тааруу байгаатай холбоотой. Улс төрийн нам иргэдийн улс төрийн болон сонгуулийн боловсролыг нэмэгдүүлэх үүрэгтэй. Манай намууд, төрийн болон төрийн бус байгууллага, судлаачид энэ асуудлыг анхаарлын гадна талд орхидог.



Олон улсын парламентын холбооны гишүүн 186 орны 109 нь сонгуульд оролцож саналаа өгөх эрхийг 18 нас гэж зөвшөөрсөн байна.

Бразил, Куба, Иран зэрэг улсууд 16 нас, зарим улсуудад 19-21 нас гэж тогтоосон байдаг. Манай улсад олон улсын жишгийн дагуу Сонгуулийн тухай хуулиар 18 нас хүрсэн иргэд сонгуульд оролцож саналаа өгдөг бөгөөд сонгуулийн насны нийт иргэдийн ихэнх хувийг 18-35 насны залуучууд эзэлж байна.


2012 оны УИХ-ын сонгуульд 18-35 насны залуусын 60 хувь нь оролцоогүй буюу саналаа өгсөн сонгогчдын 10 хувь нь 18-25 насны

залуучууд, 25 хувь нь 18-35 насны залуус байжээ. 2016 оны УИХ-ын сонгуулийн жилд ойролцоогоор 192 мянган залуучууд 18-21 насны бүлэгт дэвшиж сонгууль өгөх эрхтэй болсон бөгөөд 18-25 насны залуучуудын 46.7 хувийг эзэлж байна. Үндэсний статистикийн хорооны шинжилгээгээр 18-25 насны залуучуудын сонгуулийн идэвх хамгийн муу гэж тоон судалгаа гарсан. Энэ насны бүлгийн 2 хүн тутмын нэг буюу ойролцоогоор 50 хувь нь сонгуульд оролцоогүй байна. Энэ нь шинээр сонгууль өгөх эрхтэй болсон залуучуудын хувийн жингээс өндөр үзүүлэлт юм.

Нийт сонгогчдын сонгуулийн идэвх нь нас ахих тусам нэмэгдэж байгаа нь доорх зургаас харагдаж байна.



▼ Зураг 3. УИХ-ын сонгуульд сонгогчдын оролцоо, насны бүлгээр, мян хүн, хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны шинжилгээ, 2016

Насны бүлэг ахих тусам сонгуулийн идэвх нэмэгдэж байгаа бөгөөд 60-аас дээш насныхны хувьд 100 хүн тутмын 97 нь санал хураалтад оролцсон байна. Эндээс залуу сонгогчдыг саналаа өгөхийг уриалах, санал өгч байгаа нь төрийн эрх барихад оролцож буй үйл хэрэг, ардчилсан улсыг хөгжүүлэх боломж зэргээр ойлгуулж идэвхжүүлэх, хариуцлагажуулах шаардлагатай байна.

2012 оноос хойш залуучууд сонгуульд оролцох оролцоо бага байгааг олон нийт шүүмжилж, залуучуудын сонгуулийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагууд санаачлан сургалт хийх, сурталчлах ажлуудыг бага ч гэсэн хийж байна. Гэтэл энэ нь зөвхөн сонгуулийн жил, эсвэл сонгуулийн идэвхтэй сурталчилгаа эхлэх хэсэгхэн цаг хугацаанд хийгддэг нь үр дүн муутай. Мөн сонгуулийн үеэр сонгуульд саналаа өгсөн иргэдэд гар утасны нэгж өгөх,

бизнесийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд үнэгүй кофе, хямдралтай бүтээгдэхүүн авахыг санал болгодог зэрэг урамшууллын эрхүүдийг сонгогчдод санал болгодог. Гэтэл ардчилал, хүний эрх, эрх чөлөө, сонгуулийн үнэ цэнийг мэддэг сонгогчид сонгуульд саналаа өгсний төлөө урамшуулал авах биш, өөрсдөө идэвхтэйгээр сонгуулийн мөрийн хөтөлбөрийг харьцуулан уншиж судалдаг, хариуцлагатай сонголт хийдэг иргэд байх ёстой.

2021 онд “Нийгэм улс төрийн боловсрол” төрийн бус байгууллага Монгол дахь Конрад Аденауэр сангийн дэмжлэгтэйгээр “Z үеийн залуучуудын улс төрийн оролцоог тодорхойлох судалгаа”-г хийж гүйцэтгэсэн. Уг судалгааны хүрээнд улс төр, сонгуулийн оролцооны асуудлаар 18-25 настай залуучуудтай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас залуучуудын сонгууль болон улс төрийг сонирхдоггүй хэд хэдэн шалтгаан байгаа нь ажиглагдлаа.



Уг судалгааны хүрээнд улс төр, сонгуулийн оролцооны асуудлаар 18-25 настай залуучуудтай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас залуучуудын сонгууль болон улс төрийг сонирхдоггүй хэд хэдэн шалтгаан байгаа нь ажиглагдлаа.

-Улс төрийн талаарх ойлголт муу, улс төрийн нийгэмшлийн агентуудын нөлөө хангалтгүй.

-Залуучууд сонгуулийн үеэрх нэрдэвшигчид болон намуудын мөрийн хөтөлбөрийг уншиж танилцдаггүй, энэ талаарх ойлголт байхгүй учраас мөрийн хөтөлбөрийг сонирхдоггүй.

-Улс төрчдийн сонгогчдын саналыг худалдан авч буй байдал, худал амлалт өгдөг зэрэг хандлага таалагддаггүй учраас улс төрчдийг бүгд адил гэж боддог.

-Өөрсдийн үеийн залуучууд аль нэг улс төрийн намд орох, хэн нэгэн улс төрчийн туслах хийж түүний багт "цүнх баригч" хийж байгаа нь сурсан мэдсэнээ ашиглаж шударгаар хөдөлмөрлөх, хийж бүтээж байгаагаас өөр байдаг тул улс төрийг сонирхдоггүй.

-Сонгуулийн тухай хууль, сонгуулийн тогтолцоо, сонгуулийн тойрог, нэр дэвшигчдэд ямар шаардлага тавьдаг зэргийг мэддэггүй учраас сонгуулийг төдийлөн тоодоггүй, саналаа өгдөггүй.

-Сонгууль болон улс төрийн талаарх хэвлэл мэдээллийн хэрэгслээр гардаг нэвтрүүлгүүд оновчтой биш.

-Нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл ойлгомжгүй, цахим сүлжээн дэх мэдээллийн урсгал хэт их, түүнийг сонирхдоггүй.

-Фэйсбүүкийн орчинд улс төр, сонгуулийн талаарх мэдээлэлд саналаа хэлэх, бичих нээлттэй боловч твиттерт залуучуудын оролцоо бага, хэдий оролцоо байсан ч залуучуудын санал төдийлөн олон нийтэд хүрдэггүй.

-Сонгуулийн дүн тодорхой байдаг, миний саналын нөлөө байхгүй гэж боддог.

-Сонгуульд залуучуудын оролцоо бага гэдгийг хэт их шүүмжилж байгаа нь эргээд залуучуудыг тухайн асуудалд оролцох идэвх, сонирхлыг няцаадаг.

Эндээс дүгнэхэд, залуучуудын сонгуулийн ирц, оролцоо хангалтгүй, шийдвэр гаргах түвшинд манлайлал хязгаарлагдмал байна. Залуучуудын хэрэгцээ шаардлага, хүсэл тэмүүлэлд илүү анхаарал хандуулж, шийдвэрлэх арга замыг тодорхойлоход тэдний оролцоог хангах нэн шаардлагатай байна.

Иймээс Сонгуулийн ерөнхий хороо, төрийн болон төрийн бус байгууллагууд, улс төрийн нам, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулийн удирдлага, багш, судлаачид залуучуудыг орчин үеийн мэдээллийн технологийн дэвшил, хэвлэл мэдээллийн хэрэгслийг нийгмийн амьдралд илүү идэвхтэй оролцоход ашиглах боломж нээлттэй байгаа зэргийг бүрэн ашиглаж сонгуульдаа идэвхтэй оролцохыг уриалах, идэвхжүүлэх, заах, үлгэрлэх зэргээр ажиллах нь чухал байна. Ялангуяа сонгуульд анх удаа оролцож байгаа, эсвэл оролцохгүй байгаа залуучуудад чиглэсэн сонгогчдын боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, залуучуудын илүү идэвхтэй оролцоог хангах сайн дурын ажиллагааны бүтцийг сайжруулж, нийгэм -улс төрийн мэргэжлийн оюутнуудын оролцоог түлхүү нөлөөтэй байхаар оролцуулах, цаашлаад залуучуудаас бүрдсэн иргэний нийгмийн байгууллагуудын төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, бодлогод нөлөөлөх боломжийг олгох нэн шаардлагатай байна.



Залуучууд сонгуульд саналаа өгөх эрхээ эдлэхгүй бол хэн нэгэн таны өмнөөс сонголт хийж, эдлэгдээгүй эрх үгүй болж, таны хөгжих, сайхан амьдрах, шударгаар хөдөлмөрлөх нөхцөл хумигдсаар л байх болно.

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ҮЕЭР ТҮГЭЭСЭН МЭДЭЭЛЛИЙН МОНИТОРИНГ

Бүгд Найрамдахчуудын
олон улсын хүрээлэн
Хэвлэлийн хүрээлэн



Монгол Улс дөрвөөс зургаан жилд гурван удаа улс төрийн сонгууль хийдэг. Ойр ойрхон давтагдах сонгуулийн сурталчилгаа нь нийгмийн мэдээллийн сүлжээ, тэр дундаа Фэйсбүүк, Твиттерийг мэдээлэл харилцааны гол суваг болгон эрчимтэй ашиглах болсон энэ үед олон боломж ба сорилтуудыг дагуулж байна. Нийгмийн мэдээллийн сүлжээ ашиглаж үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь зарим талаар худал, бүрэн бус, дэгсдүүлсэн, гуйвуулсан мэдээллийн тархалтын хүрээг улам тэлэх нөхцөлийг бүрдүүлж буй нь анхаарал татсан асуудал болсон.

Үүнтэй холбогдуулан, Хэвлэлийн хүрээлэнгээс улс төрийн сонгуулийн сурталчилгааны үеэр худал мэдээллийг түгээж буй хэв маяг, орчин нөхцөл, арга технологийг тодорхойлох, баримтжуулан тайлбарлах зорилгоор 2020 оны Иргэдийн Төлөөлөгчдийн урал (ИТХ)-ын сонгууль болон 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн албан ёсны кампанит сурталчилгааны үеэр уламжлалт мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн мэдээллийн сүлжээнд мониторинг хийж, судалгааны дүнгээ олон нийтэд танилцууллаа. Энэхүү судалгааг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн (БНОУХ)-гээс хэрэгжүүлж буй Монгол Улс дахь “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд хийсэн юм.

1 Судалгааны арга зүй ба түүвэр.

Судалгаанд өдөр тутмын хоёр хэвлэл, орон нутгийн гурван сонин хэвлэлийг сонгож сонгуулийн албан ёсны сурталчилгааны үеэр гарсан сонгуультай холбоотой 90 гаруй нэгж мэдээллийг түүвэрлэж, нэг бүрчлэн задлан шинжлэв.

Судалгаанд хамруулсан сонин хэвлэлийн дугаар, сонгуультай холбоотой нэгж мэдээллийн тоо

ӨГЛӨӨНИЙ СОНИН

23

ИТХ-ын сонгууль
(2020.09.30 – 2020.10.13)

7

Ерөнхийлөгчийн сонгууль
(2021.05.24 – 2021.06.07)

ӨНӨӨДӨР

19

ИТХ-ын сонгууль
(2020.09.30 – 2020.10.13)

15

Ерөнхийлөгчийн сонгууль
(2021.05.24 – 2021.06.07)

АРХАНГАЙН АМЬДРАЛ

8

-

ИТХ-ын сонгууль
(2020.09.30 – 2020.10.13)

Ерөнхийлөгчийн сонгууль
(2021.05.24 – 2021.06.07)

НИЙТ
67 22

ИТХ-ын сонгууль
(2020.09.30 – 2020.10.13)

Ерөнхийлөгчийн сонгууль
(2021.05.24 – 2021.06.07)

ЗАВХАН

7

-

ИТХ-ын сонгууль
(2020.09.30 – 2020.10.13)

Ерөнхийлөгчийн сонгууль
(2021.05.24 – 2021.06.07)

ХЭНТИЙН МЭДЭЭ

10

-

ИТХ-ын сонгууль
(2020.09.30 – 2020.10.13)

Ерөнхийлөгчийн сонгууль
(2021.05.24 – 2021.06.07)

Хоёрдугаарт, өргөн нэвтрүүлгийн хоёр телевизийн оргил цагийн мэдээллийн хөтөлбөрөөр олон нийтэд хүрсэн сонгуультай холбоотой 217 (ИТХ-ийн сонгуулиар 85, Ерөнхийлөгчийн сонгуулиар 132) нэгж мэдээллийг задлан шинжилгээнд хамруулав.

Судалгаанд хамруулсан сонгуультай холбоотой телевизийн сувгаар цацагдсан нэгж мэдээллийн тоо

МҮОНТ

32

34

ИТХ-ын сонгууль
(2020.09.30 – 2020.10.13)

Ерөнхийлөгчийн сонгууль
(2021.05.24 – 2021.06.07)

НИЙТ
85 132

ИТХ-ын сонгууль
(2020.09.30 – 2020.10.13)

Ерөнхийлөгчийн сонгууль
(2021.05.24 – 2021.06.07)

ТВ-9

53

98

ИТХ-ын сонгууль
(2020.09.30 – 2020.10.13)

Ерөнхийлөгчийн сонгууль
(2021.05.24 – 2021.06.07)

Гуравдугаарт, нийгмийн мэдээллийн сүлжээ буюу социал медиа хэрэглэгчдийн дунд тархсан сонгуультай холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хамгийн түгээмэл хэв маяг, арга барилыг тодорхойлохыг зорив. Ингэхдээ хоёр сонгуулийн албан ёсны сурталчилгааны үеэр (2020.09.30 – 2020.10.13 ба 2021.05.24 – 2020.06.07 хооронд) хамгийн олон дагагчтай байсан 12 Фэйсбүүк хуудсанд нийтлэгдсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийв. Үүнд, цаг үеийн мэдээллийн хэрэгслийн гурван хуудас (“Ikon News”, “Zarig.mn”, “Tovch.mn”) багтсан бөгөөд арилжааны байгууллага болон хувь

хүнтэй холбоотой хуудсыг эс тооцов. Түүнчлэн, 2020 оны сонгуулиас хойш зарим хуудасны дагагчийн тоо өөрчлөгдсөн тул 2021 оны сонгуулийн үеэр мониторингд хамруулсан түүврийг шинэчилсэн бөгөөд Монгол Улсын эдийн засгийн дөрвөн бүсийн төлөөлөл болгож нийт 5 аймгийн 11 Фэйсбүүк группүүдээр тархсан мэдээллийг компьютерын тусгай программын тусламжтайгаар татаж мэдээллийн сан үүсгэв. Түүвэртэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг мониторингийн тайлангаас үзнэ үү.

2 Судалгааны үр дүн.

“Нийгмийн мэдээллийн сүлжээнд гуйвуулсан, төөрөгдүүлсэн мэдээлэл, хувийн үзэл бодол болон ухуулга сурталчилгаа давамгайлав”

Ялангуяа олон дагагчтай Фэйсбүүк хуудас, группээр түгээсэн сонгуультай холбоотой агуулгын дийлэнх нь буюу 75 -80 хувь нь далд ухуулга сурталчилгаа, бүрэн бус, гуйвуулсан мэдээлэл байв. Бусдад хор хохирол учруулахуйц, санаатайгаар гуйвуулсан мэдээлэл дунд нэр дэвшигч, улс төрийн нам эвслийн итгэл үнэмшлийг бууруулах, Засгийн газрын нэр хүндийг унагах, нийгэмд сөрөг хандлага төрүүлэх зорилготой агуулга ИТХ-ын сонгуулиар 63 хувь, Ерөнхийлөгчийн сонгуулиар 56 хувийг эзэлж байв.

“Сөрөг мэдээллийг улам лавшруулж түгээн дэлгэрүүлэх хандлага ихсэв”

Олон хэрэглэгчтэй Фэйсбүүк хуудас болон группүүд цахим мэдээллийн хэрэгслээр цацагдсан хортой, худал мэдээллийг хувь хүний сэтгэл хөдлөл бүхий тайлбар, сэтгэгдлийн хамт түгээн дэлгэрүүлж, улам туйлшруулах нь түгээмэл байв. Түүнчлэн дүрс бичлэг, зураг болон бичвэр тайлбарыг зориудаар эвлүүлэн аль нэг улс төрчид хамаатуулж, тодорхой мэдээлэл

буюу утга санааг хөнгөн, хошин, зугаатай, хоржоонтой, сүржин, түгшүүртэй янз бүрийн хэлбэрээр мийм (meme) болгон түгээх нь сүүлийн үед улс төрийн сурталчилгааны түгээмэл урсгал болоод байна. Үүгээр ч барахгүй, ийм төрлийн мэдээллээр дагнан ажилладаг Фэйсбүүк хуудас (жишээлбэл, “Хатуу мэдээ”) олширсныг мониторингийн тайланд баримтжуулсан.

Ташрамд дурдахад, 2020 онд Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр Хэвлэлийн хүрээлэнгээс явуулсан залуучуудын мэдээллийн зан үйлийг тодорхойлох судалгааны үр дүнгээс үзвэл¹⁹, 18-40 насны залуучууд олон төрлийн мэдээллийн эх сурвалжийг үнэлж цэгнэх мэдлэг дутмагийн улмаас Фэйсбүүкээр түгээсэн ямар ч мэдээлэлд итгэх хандлагатай байжээ. Тухайлбал, судалгаанд хамрагдсан залуучуудын 60 орчим хувь нь өөрсдийгөө мэдээллийн хэрэгслийг шүүмжлэлтэй хэрэглэх чадвартай хэмээн үнэлсэн боловч судалгааны үеэр мөн тооны хүн ялгаварлан гадуурхсан болон үзэн ядалтыг дэвэргэсэн хортой агуулгыг үнэлж тодорхойлж чадаагүй юм. Мөн талаас илүү буюу 57 хувь нь хэт нэг талыг барьсан өрөөсгөл мэдээллийг тэнцвэртэй мэдээллээс ялгаж чадаагүй байна.

“18-40

насны залуучууд олон төрлийн мэдээллийн эх сурвалжийг үнэлж цэгнэх мэдлэг дутмагийн улмаас Фэйсбүүкээр түгээсэн ямар ч мэдээлэлд итгэх хандлагатай байжээ.

¹⁹ Залуучуудын мэдээллийн зан үйл, боловсролын түвшний судалгаа. Хэвлэлийн Хүрээлэн, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн. 2020 он.

**“Фэйсбүүк дэх сонгуультай холбоотой
мэдээлэлд эрэгтэй нэр дэвшигчдийн тухай
агуулга давамгайлж байв.”**

2020 оны ИТХ-ын сонгуулийн мэдээлэлд жендэрийн тэнцвэр илт алдагдсан байв. Тухайлбал, эмэгтэй нэр дэвшигчид сонгуульд оролцсон бүх нэр дэвшигчдийн 32 хувийг эзэлж байсан хэдий ч, аль нэг эмэгтэй улс төрч, нэр дэвшигчийг дурдсан агуулга сонгуультай холбоотой нийт мэдээллийн дөнгөж гурван хувийг, харин эрэгтэй нэр дэвшигчдийг дурдсан мэдээлэл 57 хувийг эзэлж байв. Харин үлдсэн 40 хувь нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг аль алиныг нь багтаасан хэсэг бүлгүүдийн тухай байжээ. Харин ерөнхийлөгчийн сонгуулийн нэр дэвшигчид бүгд эрэгтэй байсан бөгөөд, эмэгтэй улс төрчийг дурдсан агуулга ИТХ-ын сонгуулийн үеийнхтэй адилаар нийт мэдээллийн гурван хувийг эзлэв.


**“Уламжлалт мэдээллийн хэрэгслээр
гүнзгийрүүлж судалсан, задлан шинжилсэн
сэтгүүл зүйн бүтээл, сонгогчийн боловсролд
зориулсан мэдээлэл хангалтгүй гарав”**

2020 оны ИТХ-ын сонгуулийн үеэр сонинд нийтлэгдсэн сонгуультай холбоотой мэдээллийн 64 хувь нь, ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр 74 хувь нь цаг үеийн үйл явдлын талаар товч мэдээлсэн буюу үйл явц, нөхцөл байдлыг нь тайлбарлаж, задлан шинжлээгүй бүтээл байв. Өөрөөр хэлбэр сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр дэвшигчдийн үүрэг амлалт болон сонгуультай холбоотой асуудалд дүн шинжилгээ хийж сонгогчдыг мэдээллээр хангах, сонголт хийхэд туслах үүргээ хангалтгүй биелүүлсэн байна. Ялангуяа Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр гүнзгийрүүлэн судалсан, задлан шинжилсэн сэтгүүл зүйн бүтээлийн давтамж (5%) ИТХ-ын сонгуулийн үетэй (26%) харьцуулахад тав дахин бага байв.

**“Сонгуулийн тухай болон бусад хууль
тогтоомжийг зөрчих хандлага ажиглагдав”**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 38.4 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 34.4 дүгээр зүйлүүдэд нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг сонгуулийн сурталчилгааны аливаа материал болон телевизийн нэвтрүүлэгт тодорхой харагдахуйц байдлаар товчлохгүй бичих, радио нэвтрүүлгийн эхлэл болон төгсгөлд дурдах талаар заасан байдаг. Мөн дээрх хуулиудын 47.10, 43.8 дугаар зүйлд сонгуулийн сурталчилгааны албан ёсны хугацааг дуустал нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаанаас бусад бие даасан нэвтрүүлэгт орох, ярилцлага өгөхийг хориглосон байдаг. Түүнчлэн, Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйлд сонгуульд оролцогч улс төрийн нам эвсэл, нэр дэвшигчийн алдар хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараахыг хориглосон байдаг.

Гэтэл эдгээр хуулийн заалтуудыг сонгуулийн сурталчилгааны үеэр зөрчих нь түгээмэл ажиглагдав. Тухайлбал, мэдээллийн сайтуудаар түгээсэн худал мэдээлэл эсхүл баримт нотолгоо мэтээр харуулсан хувийн үзэл бодол, далд сурталчилгаа нийлээд 2020 оны ИТХ-ын сонгуулийн үеэр 29 хувь, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр 21 хувьд хүрч байв. Түүнчлэн мониторингд хамруулсан өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн оргил цагийн мэдээллийн хөтөлбөрөөр нэвтрүүлсэн сонгуультай холбоотой агуулгын 75 хувь нь улс төрийн сурталчилгаа, үүний 97 хувь нь сэтгүүл зүйн мэдээний хэлбэрээр бэлтгэсэн далд сурталчилгаа байсан нь анхаарал татаж байна. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүд олон нийтийг чанартай мэдээллээр хангах, нийгмийн мэдээллийн орон зайг цэвэр, шударга байлгах үүргээ сонгуулийн үеэр хангалттай сайн биелүүлж чадаагүйг харуулж байна.



ГУРАВ. ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ



2020 оны ИТХ-ын сонгууль, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэлд улс төрийн нөлөө өндөр буйгаас гадна олон дагагчтай Фэйсбүүк хуудас, группээр түгээж буй мэдээлэлд суурилсан нийгмийн хэлэлцүүлэг, гуйвуулсан мэдээлэл, суртал ухуулга давамгайлж, хувийн үзэл бодлыг баримт нотолгоо мэт ашиглах явдал түгээмэл байна. Мэдээллийг зохион байгуулалттайгаар гуйвуулж, тодорхой арга технологийн тусламжтайгаар олон нийтийг төөрөгдүүлэх хандлага олширч буй нь ардчиллын үйл явцад итгэх иргэдийн итгэлд сөргөөр нөлөөлж, олны дунд үл итгэлцэл бий болгон, нийгмийн хагарал үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Тиймээс бодлого, шийдвэр гаргагчид, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагууд буюу мэдээллийн харилцааны оролцогч талууд худал мэдээллийг санаатайгаар түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг хязгаарлах асуудалд хамтран анхаарал хандуулах зайлшгүй шаардлага тулгараад байна.

Гэсэн хэдий ч, худал мэдээллийн эсрэг хуулийн элдэв хориг саад нь үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарлах буюу тодорхой зорилгоор хэтрүүлэн ашиглах өндөр эрсдэлийг давхар бий болгож байдаг тул худал мэдээллийн эсрэг хуулийн хатуу зохицуулалт хийхээс зайлсхийх нь зүйтэй хэмээн судалгааны багаас үзэв.

Тиймээс энэ судалгааны үр дүнд үндэслэж бодлого боловсруулагчид, хэвлэл мэдээллийн салбар болон олон нийтэд хандан:

1. Мэдээллийн гажуудалтай тэмцэх эрх зүйн бодлого, зохицуулалтыг хүний эрхийн олон улсын хэм хэмжээний хүрээнд боловсруулж, хэрэгжүүлэх
2. Хараат бус хэвлэл мэдээлэл, чанартай сэтгүүл зүйг дэмждэг орчныг бий болгох
3. Хэвлэл мэдээлэл, мэдээллийн сүүрь боловсролыг бүх түвшинд дэмжин хөгжүүлэх үндэсний бодлого боловсруулж хэрэгжүүлэх гэсэн зөвлөмжүүдийг мониторингийн тайлангийн хамт хүргүүлэв.

Эцэст нь, иргэдийг худал мэдээллийн эрсдэлээс хамгаалахын тулд тэдний мэдээллийн боловсролыг хөгжүүлэх, чадавхжуулах, мэдээлэл гуйвуулахад оролцогч болохгүй байх тухай ойлголтыг сайжруулах, цаашлаад чанартай сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, үүрэг хариуцлагын талаарх мэдлэгийг дээшлүүлэх нь онц чухал буйг онцлох нь зүйтэй. Үүний зэрэгцээ, сэтгүүл зүйн хариуцлагыг дээшлүүлэх, мэдээллийн гуйвуулгын цар хүрээ, хэв шинжийг үргэлжлүүлэн судалсны үндсэн дээр энэхүү хортой үзэгдлийн эсрэг өргөн цар хүрээтэй хариу арга хэмжээ авах шаардлага тулгараад байна.



5

СОНГУУЛЬ ДЭЛХИЙН УЛС ОРНУУДАД

- Бүгд Найрамдах Солонгос улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай
- Сонгуулийн автоматжуулсан систем, түүний төрөл
- Олон Улсын сонгуулийн хуанли -2022

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

53



Б.ОЮУМАА

Эрх зүйн шинжлэх ухааны магистр
Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн дарга

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН СОНГУУЛЬ

БНСУ-ын Үндэсний сонгуулийн комисс нь Төрийн албаны сонгуулийн тухай хуульд заасны дагуу Ерөнхийлөгчийн сонгууль, Үндэсний ассамблейн сонгууль, орон даяар нэгэн

зэрэг явагдах орон нутгийн сонгуулийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг.

Үндэсний сонгуулийн комисс өөрийн орны сонгуулийн үндсэн зарчмыг дараах байдлаар тодорхойлдог.



Бүх нийтийн зарчим

Сонгуулийн насанд хүрсэн иргэн бүр нийгмийн байдал, арьсны өнгө, шашин шүтлэг, хүйс, боловсрол, өмч хөрөнгөөрөө ялгаварлагдахгүйгээр сонгох эрх эдэлнэ.

Тэнцүү саналын эрх

Хүн бүр нэг саналын эрхтэй.

Шууд зарчим

Сонгуулийн эрх бүхий иргэд санал хураалтад шууд оролцох боломжтой.

Нууцаар санал өгөх

Сонгогчийн аль нэг улс төрийн нам, нэр дэвшигчийг сонгосныг хэн ч мэдэхгүй байх ёстой. Сонгогч нууцаар санал өгөх зарчим нь сонгогч эд мөнгө, айлган сүрдүүлэлт, хамаатан садны нөлөө гэх мэт хөндлөнгийн нөлөөлөл, оролцоогүйгээр чөлөөтэй, шударга санал өгөх эрхээ эдлэх боломжийг олгоно.

Чөлөөт сонгууль

Сонгуулийн тухай хууль тогтоомжид заасны дагуу сонгогч сонгуульдаа үнэнчээр оролцож, эрхээ эдлэх "үүрэг" хүлээсэн ч оролцохгүй бол тэдгээрт хариуцлага хүлээлгэхгүй.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгч нь тус улсын Үндсэн хуульд заасанчлан төрийн тэргүүн мөн бөгөөд гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэйгээр төлөөлдөг. Түүнчлэн гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхийлөгчийн тэргүүлсэн Засгийн газар хэрэгжүүлдэг.

Тус улсын Ерөнхийлөгчид 40 нас хүрсэн, сүүлийн 5 жил эх орондоо оршин суусан иргэн нэр дэвших ба Үндсэн хуульд нь зааснаар бүх иргэд /сонгуулийн насны/ нийтээрээ, адил тэгш, шууд сонгох эрхтэй оролцож, саналаа нууцаар гаргаж сонгодог.

Ерөнхийлөгчийн сонгууль нь харьцангуй олонх / first past the post (FPTP) system /-ын системээр явагддаг ба хэрэв нэг нэр дэвшигч өрсөлдөгчгүйгээр сонгуульд оролцсон бол тухайн нэр дэвшигч нийт сонгогчдын саналын гуравны нэгээс дээш хувийн санал авч байж сонгогдох боломжтой.

Санал хураалтын үр дүнд хамгийн олон санал авсан нэр дэвшигч 2 болон түүнээс дээш байвал Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн олонхын ирцтэйгээр нээлттэй хуралдаж, уг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсонд тооцохоор Үндсэн хуульдаа заасан байдаг.

БНСУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг 5 жил тутамд, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас 70 хоногийн өмнө Лхагва гаригт зохион байгуулдаг бөгөөд 20 дахь удаагийн ээлжит сонгуулийн санал хураалтыг 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдөр явууллаа. Харин Ерөнхийлөгчийн 19 дэх удаагийн буюу ээлжит бус сонгууль нь 2017 оны 5 дугаар сарын 09-ний өдөр явагдаж, одоогийн Ерөнхийлөгч Мүн Жэ Ин сонгогдож байжээ.

Дэлхий нийтэд тархсан шинэ коронавируст халдварын тархалттай нөхцөлд сонгууль зохион байгуулагчид, сонгогчдыг халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын улмаас тусгаарлагдсан, эмчлэгдэж байгаа сонгогчдынхоо эрхийг хангах тал дээр анхааран ажиллаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь бусад олон оронд сонгуулиа амжилттай зохион байгуулахад нь туршлага, жишиг болж чадсан билээ. Өмнөд Солонгос Улс коронавирусын омикрон давалгаанд өртөж, өдөртөө 300,000 гаруй шинэ тохиолдол

бүртгэгдэж байсан хүндхэн нөхцөлд энэ удаагийн сонгуулиа явуулсан юм. Үүнд 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр болсон Үндэсний Ассамблейн ээлжит сонгуулиа товлосон хугацаанд нь амжилттай зохион байгуулж, хөл хорио, хязгаарлалттай нөхцөлд ч сонгууль явуулах боломжтойг дэлхий нийтэд нотлон харуулсан өмнөх туршлага нь давуу тал болж байв. Сонгогчдоос өмнөхийн адил амны хаалт зүүх, бээлий өмсөх, саналаа өгсний дараа гараа ариутгахыг шаардаж байлаа.



Сонгуулийн өдөр Өмнөд Солонгосчууд 06:00 цагт нээгдсэн санал авах байруудад очиж саналаа өгсөн бөгөөд 18:00 цагт хаагдах хүртэл КОВИД-оор өвдөөгүй хүмүүс очиж саналаа өгчээ. Харин санал хуралт дууссанаас хойших 90 минутын турш буюу 19:30 цаг хүртэл “Ковид-ээрэг” сонгогчид санал өгөх боломжтой байдлаар зохион байгуулалт хийсэн байна. Сонгуулийн санал авах өдрийн байдлаар нэг сая гаруй хүн шинжилгээний эерэг хариутай гэртээ тусгаарлагдсан байсан талаар эрүүл мэндийн албаныхан нь мэдэгдэж байлаа. Энэ оны 2 дугаар сард тус улс сонгуулийн хуулиа өөрчилснөөр халдварт өвчний улмаас тусгаарлагдсан, хэвтэн эмчлүүлж байгаа сонгогчдод санал өгөх боломжийг олгосон юм.

Урьдчилсан санал хураалт буюу санал хураалтын өмнөх хоёр долоо хоногийн хугацаанд 44 сая сонгуулийн эрх бүхий иргэд, өөрөөр хэлбэл, нийт сонгогчдын 37 хувь нь саналаа урьдчилан өгч дээд амжилт тогтоосон нь 2013 онд энэхүү системийг нэвтрүүлснээс хойших хамгийн өндөр үзүүлэлт байжээ.

Эх сурвалж: Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний сонгуулийн комиссын цахим хуудас
www.nec.go.kr

СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМ, ТҮҮНИЙ ТӨРӨЛ

Докторант П.Алтанчимэг,
Мэдээллийн технологийн төвийн ахлах референт



Сонгуулийн автоматжуулсан системийн техник хэрэгслийг сонгогчийн санал авч, тоолоход ашиглах бөгөөд энэ нь санал авах, тоолох ажиллагааны нэг арга, хэлбэр юм. Сонгуулийн автоматжуулсан системийн хөгжил, автоматжуулсан системийн үндсэн төрлүүдийн талаар товч танилцуулъя.

Сонгуулийн автоматжуулсан системийн дараах төрлүүд ашиглагддаг:²⁰

1. Цоолбор картаар санал өгөх, тооцоолох /Punch card voting
2. Оптик сканер/Optical scanning systems
3. Мэдрэгч дэлгэц (DRE)/Direct recording electronic systems
4. Цахим санал хураалт/Internet voting

Сонгуулийн автоматжуулсан системийг 1960-аад оноос хойш ашиглаж эхэлсэн бөгөөд цоолтуурын карт зах зээлд нэвтэрч, дараа нь оптик сканерын технологи, DRE болон интернет нэвтэрсэн.

Цоолбор картаар санал өгөх, тооцоолох

Сонгогч саналын хуудсыг /карт/ цоолтуурын төхөөрөмж ашиглан нэр дэвшигчийн дугаарын өмнө цоолох байдлаар саналаа тэмдэглэх технологи юм. Сонгогч саналаа тэмдэглэсний дараа картыг тооцоолох машинд хийх, эсвэл саналын хайрцагт хийж санал өгнө. Саналын хайрцагт хийсэн саналын хуудсыг санал хураалт дууссаны дараа тооллогын төв рүү зөөвөрлөн нэгдсэн тооллого хийдэг байжээ.

АНУ-д 1964 онд Жоржиа мужид Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд цоолтуурын карт болон тооцоолох машиныг **анх ашиглаж байжээ**.



АНУ-д “Votomatic” болон “Datavote” картуудыг өргөн хэрэглэдэг байсан бөгөөд нэг карт нь саналын хуудас дээр нэр дэвшигчийн нэр хэвлэгддэг байсан бол нөгөө төрөлд нэр дэвшигчийн дугаар хэвлэгдэж, нэр дэвшигчийн мэдээлэл болон картыг бөглөх зааварчилгааг тусдаа ном байдлаар хэвлэдэг байжээ.

Оптик сканер

Сонгогч нэр дэвшигчийн нэрийн өмнөх дүрсийг дүүргэн будах замаар саналын хуудсанд байрлах саналаа тэмдэглэн санал тоолох төхөөрөмжид хуудсыг уншуулах замаар санал өгөх технологи. Оптик сканер бүхий санал тоолох төхөөрөмж нь санал тэмдэглэсэн саналын хуудасны зургийг сканердаж, тусгай програм хангамжаар тооцоолол хийж саналыг тоолох төхөөрөмж юм.




²⁰ <https://aceproject.org/ace-en/topics/et/eth/eth02/eth02b/eth02b4>

Энэ төрлийн санал тоолох төхөөрөмжийг улс орнууд хамгийн түгээмэл хэрэглэдэг бөгөөд үндсэн зарчим нь ижил боловч тухайн улс орны нөхцөл байдалд тохируулан нутагжуулах байдлаар ашигладаг. Олонх улсууд санал авах байранд санал тоолох төхөөрөмжийг байршуулан санал тоолох үйл ажиллагааг явуулдаг бол зарим нэг улсад санал тоолох тусдаа тооллогын төв ажиллуулж, санал хураалт дууссаны дараа нэгтгэн тоолох байрлаар оптик сканер бүхий санал тоолох төхөөрөмжийг ашигладаг.

Мэдрэгч дэлгэц (DRE)

Direct recording electronic-р сонгогчид мэдрэгчтэй дэлгэцээс нэр дэвшигчдийн нэрсийг харж, сонгохыг хүссэн нэр дэвшигчийг дэлгэц дээрээс сонгох байдлаар саналаа өгнө. Өөрөөр хэлбэл сонгогч саналын хуудас дээр нэр дэвшигчийг сонгож тэмдэглэгээ хийхгүй, мэдрэгч дэлгэц дээрээс сонголтоо хийж, баталгаажуулах юм. DRE-ийн хэрэглээ өргөжиж энэ төхөөрөмжөөр санал өгөх сонгогчдын хувь нэмэгдэж байна.



Санал хураалтын баталгаажуулалт болон дүн нэгтгэх үйл ажиллагааг төхөөрөмж өөр дээрээ дүнгээ нэгтгэн хадгалж, санал хураалт дууссаны дараа төв серверт дүнгээ дамжуулах, эсвэл тухайн төхөөрөмжийн хадгалах төхөөрөмжөөс өөр төхөөрөмжид холбож дүн дамжуулах зэрэг аргыг хэрэглэх боломжтой ба улс орнуудын өөрийн онцлогт тохируулан хэрэглэдэг.

Internet voting

Цахим санал хураалт /Internet voting/ нь цахим орчинд сонгогчийг таньж баталгаажуулах, санал авах, тоолох үйл ажиллагаа юм. Цахим санал хураалтын гол давуу тал нь сонгогч газар зүйн байршил үл харгалзан интернэтээр санал өгөх боломж юм.

Одоогийн байдлаар 13 орчим улс цахим санал хураалтыг хэрэглэж байгаагийн олонх нь тодорхой зорилтот бүлэг сонгогчид буюу гадаад улсад суугаа иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд мөн зарим нэг муж, хотын иргэдэд цахимаар санал өгөх боломжийг олгож байна.



Улсын хэмжээнд буюу бүх сонгогчдод цахим санал хураалтыг ашиглах боломжийг бүрдүүлсэн улс бол Эстони улс бөгөөд тус улсын сонгогчдын 47% нь цахимаар саналаа өгч сонгуульд оролцож байна.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



ОЛОН УЛСЫН СОНГУУЛИЙН ХУАНЛИ -2022

Олон улсын сонгуулийн тогтолцооны сан (International Foundation for Electoral Systems) нь ардчиллын замаар замнаж буй 145 орныг эгнээндээ нэгтгэсэн, дэлхий дахины ирээдүйн сайн сайхны төлөөх ардчиллыг дэмжих алсын хараатай, ашгийн бус, нам бус байгууллага юм. Тус байгууллага нь дэлхийн улс орнуудын төрийн байгууллагууд, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажилладаг.

Ардчиллыг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр дэлхийд тэргүүлэн ажиллах зорилготой энэхүү сонгуулийн холбогдолтой судалгаанууд нь найдвартай эх сурвалж бүхий хэрэглэхэд энгийн, олон талын мэдээллийг багтаасан байдаг. Тус байгууллагаас жил бүр гаргадаг сонгуулийн хуанлийг танилцуулж байна.



Серби

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Ерөнхийлөгч,
Үндэсний Ассамблей

2022-04-03



Коста Рика

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Ерөнхийлөгч

2022-04-03



Унгар

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Үндэсний Ассамблей,
Ард нийтийн санал асуулга

2022-04-03




Гамби

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Гамбийн Үндэсний Ассамблей

2022-04-09




Франц

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Ерөнхийлөгч
1 дэх шат

2022-04-10



Франц

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Ерөнхийлөгч
2 дахь шат

2022-04-24



Словени

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Словенийн Үндэсний
Ассамблей

2022-04-24



Австри

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Ерөнхийлөгч

2022-04-30



Филиппин

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Ерөнхий сонгууль

2022-05-09




Ливан

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Парламент

2022-05-15




Австрали

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Австралийн Сенат

2022-05-21



Австрали

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Австралийн Төлөөлөгчдийн
танхим

2022-05-21



Колумби

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Ерөнхийлөгч

2022-05-29




Папуа Шинэ Гвиней

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Ерөнхий сонгууль

2022-06-11




Франц

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Францын Үндэсний Ассамблей

2022-06-30



Япон

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Япон Улсын Зөвлөхүүдийн
танхим

2022-07-25



Конго (Браззавилле)

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Конгын Үндэсний Ассамблей

2022-07-31




Сенегал

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Сенегалын Үндэсний
Ассамблей

2022-07-31




Кени

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Кенийн Сенат

2022-08-09




Кени

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Ерөнхийлөгч

2022-08-09



Кени

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Кенийн Үндэсний Ассамблей

2022-08-09



Швед

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Шведийн Парламент

2022-09-11



Латви

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Латвийн Парламент

2022-10-01



Бразил

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Бразилийн Депутатуудын
танхим

2022-10-02



Бразил

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Ерөнхийлөгч

2022-10-02



Бразил

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Бразилийн Холбооны Сенат

2022-10-02



Словени

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Ерөнхийлөгч

2022-10-31



Босни, Герцоговин

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Ерөнхийлөгчийн Тамгын
газрын даргын сонгууль

2022-10-31



Босни, Герцоговин

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Босни, Герцоговиний
Төлөөлөгчдийн танхим

2022-10-31



АНУ

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

АНУ-ын Төлөөлөгчдийн
танхим

2022-11-08



АНУ

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

АНУ-ын Сенат

2022-11-08




Австри

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Ерөнхийлөгч

2022-11-30



Фижи

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Фижийн Төлөөлөгчдийн
танхим

2022-11-30



Бахрейн

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Бахрейны Төлөөлөгчдийн
зөвлөл

2022-11-30



Судан

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Ерөнхийлөгч

2022-12-31



Судан

СОНГУУЛИЙН ТӨРӨЛ

Суданы Үндэсний Ассамблей

2022-12-31



УИГЧИДЫН
СҮДАЛ АРХИВ







Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо
Засгийн газрын 11 дүгээр байр
Ж.Самбуугийн гудамж,
Улаанбаатар – 15141, Монгол Улс
Санал хүсэлт хүлээн авах хаяг:
gecm@gec.gov.mn
(976) -51 263602

UIH.MN
СУДАЛГААНЫ САН